

Бхагавад Гитагийн тухай...

Сүнсний тухай эрдэм ухаан.

Энэ дэлхийн хүмүүс бараг бүгдээрээ өөрийгөө бие махбодтойгоо адилтган үзэхүйн хий хуурмагт оршин байдаг бөгөөд хүний үйлдэж байгаа аливаа үйл ажиллагаа нь бие махбодийн хэрэгцээг л хангахад чиглэгддэг. Бхагавад Гита-д Кришнагийн биднийг гэгээрүүлэхээр айлдсан эхний айлдвар бол бид бие махбодь биш, харин сүнс гэдэг явдал. Бага зэрэг бодож үзэх аваас үүнийг амархан ойлгох болно.

Сүнс оршин байдгийн баталгаа.

Хэн нэгэн хүнийг нас барахад бид: “Тэр явчихлаа, талийн одлоо.” гэж ярьцгаадаг. Гэхдээ хэн явчихсан гэж? Бие махбодь нь бол энд байж л байгаа шүү дээ. Амьдралын эх булаг сүнс бие махбодиос гарч одсон хэрэг. Иймээс тэр хүнийг амьгүй болсон, үхсэн гэж ярьдаг, үздэг.

Жинхэнэ “Би” бол бие махбодь, ухаан болон оюунаас ялгаатай гэдэг зөн билгийн гэмээр ойлголт бидэнд байдаг. Бид: “Миний гар.”, “Миний толгой.” ... гэх мэтээр ярьдаг. Толгой дээрх үснээсээ авахуулаад хөлийн хуруунуудынхаа хумсны үзүүрийг хүртэл, энэ бол минийх гэж хэлж, ярьдаг. Энэ нь, бие махбодийн бүх хэсгүүд хэн нэгэн эзэнд харьяалагддаг гэдгийг зааж байна. Нүд, чих болон тархи зэрэг нь эрхтэнгүүд бөгөөд бид тэдгээрийн тусламжтайгаар хардаг, сонсдог, боддог. Эдгээр эрхтэнгүүд өөрсдөө бие даан ямар ч үйлдлийг хийж чадахгүй. Амьгүй болсон буюу үхсэн байгаа бие махбодид нүд, чих болон тархи мөн л байсаар байдаг, гэхдээ сүнс-жолооч бие махбодийг орхисон болохоор түүний үйл ажиллагаа нь зогссон байгаа.

Амьд оршнол бол ухамсартай билээ. Нар гэрэл болон дулаанаа хаа сайгүй түгээн тархааж байдагтай адилаар сүнс ухамсрыг бие махбодь даяараа, хөлийн хурууны үзүүрээс авахуулаад толгойн орой хүртлээ нэвчүүлэн тархаадаг. Чухамхүү ухамсар л биднийг хөдөлгөөн хийх, мэдрэмж мэдрэх, бодож сэтгэх болон бусад бүх үйлүүдийг хийж үйлдэхийг өдөөдөг. Иймээс УХАМСАР бол СҮНС ОРШИН БАЙГААГИЙН шинж тэмдэг юм. Ухамсар— энэ бол амьгүй бие махбодийг амьдаас ялгаруулдаг тэр зүйл. Улаан өнгө гэсэн үгийг хэлэхэд: “Би улаан өнгийг харж байна.” гэж хариулж чадах машиныг зохион бүтээж чадаж байж болох ч тэр машин ийн хариулж байх үедээ улаан өнгийг үнэхээрийн хардаг гэж үү?

Ухаан бол материаллаг уураг тархинаас ч тэр, мөн бие махбодиос ч тэр хамаардаггүй гэдэг дүгнэлтийг олон тооны тохиолдлууд дээр үндэслэн бид хийж болно. Клиник үхлийн үед сүнс бие махбодио орхин гардаг. Бие махбодиосоо гарахыг үзэж, туулсан хүмүүс бие махбодио хажуугаас, хөндлөнгөөс хэрхэн харж ажиглаж байснаа хийгээд бие махбодь нь ухамсаргүй болсон тэр үед юу болж байсан талаар ярьдаг. Иймэрхүү хэргийн олон тооны гэрч баримтууд бий: зүрхний дутагдалд орсны уршгаар ухамсаргүй төлөвт орсон хэн нэгэн нь бие махбодийнхоо гаднаас түүнийг амь оруулахыг, амьдруулахыг оролдон байгаа эмч нарыг хардаг.

Өнгөрсөн буюу урд насны амьдралын үеийн тухай салбарт нарийн судалгаанууд ч гэсэн олноор хийгдсэн. Вирджианагийн хий судлалын профессор Ян Стивенсон Карлсон хүүхдүүдэд өнгөрсөн амьдралд нь болж тохиолдсон зүйлс аяндаа санагддагтай холбоотой учир баримтуудын талаар нарийн судалгаа хийсэн. Хүүхдүүдийн санасан газар орон болон хүмүүст хамааралтай бүхий л нарийн тодорхой зүйлсийг тэр нягт нямбайгаар судалсан хийгээд алдаа мадаг гаргахгүйн тулд тэдгээрийг анхааралтайгаар шалгасан. Ингэснээр тэр: “Ухамсарт “Би” нэг физик бие махбодиос нөгөөд ордог буюу шилжин аялж явдаг.” гэсэн гайхалтай дүгнэлтэнд хүрсэн. Бие махбодийн үхэлтэй хамтаар тархинд агуулагдаж байгаа мэдээлэл устан үгүй болдог, иймээс өөр тархитай харилцан үйлдэлд орж яаж чадах юм бэ? гэж бодогдож байж болох. Тэгэхлээр, ухамсарт “Би” гэдэг бол тархинаас ялгаатай оршнол гэсэн дүгнэлтийг эндээс хийж болно.

Нэгэн эрдэмтэн, хүний бие махбодийг химийн бүрдүүлэгч хэсгүүдэд задалсан бөгөөд сүнс бол өөрийн гэсэн онцлогтой юм байна гэсэн мэдэгдэл хийсэн. Сүнс бүр өөрийн гэсэн ухамсартай салангид тусдаа бодьгал. Та өөрийнхөө бие махбодь, ухаан, оюун болон хуурмаг-эго-г ухамсарлаж мэддэг. Харин өөр хэн нэгэн хүний толгой өвдөж байгааг мэдрэх эсвэл бодол санааг нь унших боломжгүй. Тэгвэл Бурхан бүтээлийнхээ өчүүхэн жижиг хэсэг нэг бүрийг ч хүртэл ухамсарладаг буюу тэдний нэг бүрийн дотор болж явагдаж байгаа бүгдийг мэддэг. “Би, чи болон энэ бүх хаад эс оршин байсан цаг үе гэж хэзээ ч байгаагүй, мөн ирээдүйд бидний хэн нэгэн нь оршихоо болино гэсэн

явдал үгүй билээ.” (Б.-г., 2.12). “Энэхүү материаллаг ертөнцөд оршин байгаа амьд оршнолууд бол Миний мөнхийн бүрэлдхүүн жижиг хэсгүүд.” (Б.-г., 15.7).

Сүнс бол хэлбэртэй. Зарим хүмүүсийн андуу ташаагаар боддог шигээр, сүнс бол бодьгал бус гэрэл эсвэл хий хоосон биш. Сүнс бол бие нь мөнх байдал, мэдлэг болон цэнгэл жаргалаас бүрддэг гайхамшигтай сайхан бодьгал. Сүнс бол зүгээр нэг эрчим биш, сүнс бол бодьгал.

Матери бол хэлбэр дүрсгүй, материйн хэлбэрийг сүнс өгдөг. Жишээ нь та хэсэгхэн даавуу аваад хуруугаа ороох аваас хэлбэр дүрстэй болно. Харин та хуруугаа сугалаад авчихвал даавуу хэлбэр дүрсээ алдан буцаад тэнийн дэлгэгдэнэ. Яг үүн лугаа, бие махбодь дахь материаллаг найман элемент— шороо, ус, гал, хий, огторгуй, ухаан, оюун болон хуурмаг эго нь түүн дотор сүнс орсон байгаа цагт л хэлбэр дүрстэй болдог. Үхэх цаг үед сүнс бие махбодийг орхин гардаг бөгөөд бие махбодь ч ялзарч муудан хэлбэр дүрсээ алддаг.

Сүнс бол мөнх. Бурхан Кришна: “Сүнсний хувьд төрөлт, мөн үхэл гэж хэзээ ч байдаггүй. Тэр хэзээ ч үүсэж бий болоогүй, хэзээ ч үүсэж бий болдоггүй, хэзээ ч үүсэн бий болохгүй. Тэр төрдөггүй, мөнхөд оршин байдаг, анхдагч. Бие махбодь үхэж үрэгдэхэд ч тэр үхэж үрэгддэггүй.” (Б.-г., 2.20) гэж айлддаг.

Сүнс бол мөнх байдал, мэдлэг болон цэнгэл жаргалаар дүүрэн хэлбэртэй. Сүнс Бурханы оронд харьяалагддаг бөгөөд Бурхантай харьцахын тулд мөнх байдал, мэдлэг болон цэнгэл жаргалаас бүрдсэн бурханлаг биетэй байдаг. Гэвч сүнс Кришнагаас хамааралгүйгээр таашаал ханамж эдлэх хүсэлтэй болсон үедээ тэр даруйдаа л материаллаг ертөнц тийш унадаг. Тэнд тэрээр материаллаг бие махбодийн урхинд орж унан, торонд хоригдсон тоть мэт болдог. Бид яагаад зовж шаналдаг юм бэ? Яагаад вэ? гэвэл, мөнх хийгээд цэнгэл жаргалт сүнс түр зуурын, харанхуй мунхаг, аз жаргалгүй бие махбодийн урхинд баригдсан байгаа болоод л тэр.

Сүнс зүрхний орчимд байрладаг. Чийдэн өрөөг гэрлээр дүүргэдэгтэй адилаар сүнс бие махбодийг ухамсраар дүүргэдэг. Нэг газар оршин байгаа чийдэн өрөөг бүхэлд нь гэрэлтүүлдэг. Үүнтэй төстэйгөөр, хүний зүрхний орчим байрлах сүнс бие махбодийг бүхэлд нь ухамсраар дүүргэдэг. Өөрөөр хэлбэл, ухамсрыг бүхий л бие махбодь даяар нэвчүүлэн тархаадаг. Сүнс бол материаллаг бус бурханлаг учраас зүрх шилжүүлэн суулгах үед бие махбодиос зүрхтэй хамтаар гардаггүй.

Сүнс бие махбодио сольдог. “Хүн хуучирч муудсан хувцсаа тайлж хаяад шинийг өмсдөгийн адил сүнс хэрэггүй болсон хуучин бие махбодио орхин шинэ материаллаг бие махбодийг авдаг.” (Б.-г., 2.22). Яг л үүн шигээ, сүнс энэхүү бие махбодио нялх балчираас эхлэн идэр залуу дараа нь өтөл буурал болтол хувирч өөрчлөгдөхийг даган байсаар үхлийн дараагаар өөр бие махбодид шилжин ордог. Өөрийн бурханлаг мөн чанараа ухаарсан хүн иймэрхүү шилжилтэнд төөрөлдөж самууран тавгуйтдэггүй. (Б.-г., 2.13).

Сүнсний хэмжээ. “Үсний үзүүрийг 100 хэсэг болгон хуваах хийгээд дараа нь гарсан хэсгүүдийн нэгийг дахин 100 хуваах аваас үсний үзүүрийн энэхүү 10 000-ны нэг хэсэг нь сүнсний овор хэмжээтэй тэнцүү байх болно.” (Шветашватара Упанишад 5,9). Энэхүү материаллаг ертөнцөөр хэрж тэнэн явах үедээ үр хэлбэртэй оршин байх сүнс ийм овор хэмжээтэй байдаг. Гэхдээ сүнсэнд Кришнатай холбогдсон мөнхийн харьцаагаараа цэнгэн жаргадаг анхдагч жинхэнэ, сайхан, бурханлаг хэлбэр дүр байдаг. Энэ нь Эзэн албатын, найз нөхрийн, эцэг эхийн эсвэл амраг хайртын харьцаа байж болдог.

Сүнс бол ойлгож хүрэхийн аргагүй. Сүнс бол электрон микроскопоор ч хүртэл олж харах боломжгүй тийм жижигхэн. Гэхдээ тийм жижигхэн овор хэмжээг олж харах микроскопыг зохион бүтээсэн байлаа ч сүнсийг харах нь тэртэй тэргүй боломжгүй хэрэг. Материйн нарийн хэлбэр болох бодол санааг ч гэсэн бид яг тодорхойлж чаддаггүй. Тодорхойлолтоор бол, сүнс материйн хил хязгаарын чанадад оршдог. Тэр бол харагдашгүй хийгээд ухаарч хүршгүй. “Сүнс бол үзэгдэж харагдашгүй, ойлгож ухаарахын аргагүй бөгөөд мөн хувирч өөрчлөгддөггүй.” (Б.-г., 2.25).

Сүнс болон Дээд Сүнс.

Сүнснийг материаллаг ертөнцөд Бүхний Дээд Бурханы хувилгаан дүр Параматма буюу Дээд Сүнс дагалдан ирдэг. Дээд Сүнс нь сүнсстэй хамтаар нэг бие махбодиос нөгөө бие махбодид шилжин явахын зэрэгцээ түүнд санаа тавьдаг. Сүнс тодорхой нэг газарт оршин байдаг бол Дээд Сүнс хаа сайгүй залран байдгаараа түүнээс ялгаатай.

Бие даасан сүнс нэг бие махбодиос нөгөө бие махбодид Параматмагийн өршөөл нигүүлслээр шилжин ордог. Тэрээр сүнсний хүслийг, нэг найз нөгөө найзынхаа хүслийг хэрхэн биелүүлдэг шигээр биелүүлдэг. Ведэд, сүнс болон Дээд Сүнснийг нэгэн модон дээр сууж байгаа хоёр шувуутай зүйрлэдэг. Тэдний нэг нь буюу бие даасан өчүүхэн жижиг сүнс энэхүү модны үр жимсийг тоншин иддэг, харин нөгөө шувуу буюу Кришна түүнийг зүгээр ажиглаж байдаг. Хоёр шувууны зөвхөн нэг нь л материаллаг модны үр жимсэнд дур татагдан сэтгэл булаагддаг. Тэрээр гашуун үр жимсийг идэх үедээ зовж шаналдаг, амтат үр жимсийг идэх үедээ баяр хөөр болдог. Энэ явцад нөгөө шувуу найзынхаа үйлийг зүгээр л ажиглан харж байдаг.

Кришна бол энэхүү ажиглан харж байгаа шувуу, харин Түүний найз аугаа дайчин Арджуна бол үр жимс тоншин идэж байгаа шувуу. Хэдийгээр тэд найзууд ч гэсэн тэдний нэг нь эзэн, харин нөгөө нь албат. Бурхантай холбогдсон харьцаа холбооныхоо талаар санахгүй байгаа үедээ бие даасан сүнс нэг модноос нөгөө модонд буюу нэг бие махбодиос нөгөө бие махбодид шилжин явах ёстой байдаг. Материаллаг бие махбодийн модон дээр амьдарч оршнохын төлөөнөө сүнс хүнд хэцүү, хатуу ширүүн тэмцэл хийдэг. Гэхдээ Арджуна Кришнагийн айлдвар сургаалыг бишрэн дагахыг зөвшөөрч байгаа шигээр нөгөө шувууг дээдийн дээд бурханлаг номын Багшаа болгохыг зөвшөөрч байгаа сүнс дорхноо л бүхий л зовлон гаслангаасаа салан ангижирдаг. Үүнийг Катха-Упанишад болон Шветашватара-Упанишад баталдаг: “Хэдийгээр шувууд хоёулаа нэг модон дээр сууж байгаа ч тэдгээрийн нэг нь энэхүү модны үр жимсийг тоншин амталж байгаа болохоор түгшүүр зовиур болон гуниг гутралд автдаг. Гэхдээ тэрээр өөрийн Найз— Бүхний Дээд Бурхан тийш хандах аваас зовж шаналж байгаа шувуу тэр дороо бүхий л зовлонгоосоо ангижран салдаг.”

Бурхан гэж хэн бэ?

Яагаад янз бүрийн бурхад, янз бүрийн ариун гэгээн бичээсүүд байдаг вэ?

Үнэнийг эрж яваа хүний ухаанд: “Хэрвээ ганц л Бурхан байдаг юм бол яагаад ийм өчнөөн олон янзын шашнууд, өчнөөн олон янзын Бурхад байдаг юм бол? Би тэгээд эдгээрийн алиныг нь үзэж судалж, дагах болж байна вэ? Бурханы оронд хүрч очихын тулд би аль замаар нь орж замнах хэрэгтэй вэ?” гэсэн бодол заримдаа төрдөг. Бурхан бол нэг л байдаг. Иймээс ариун гэгээн бичээс ч тэр, Бурханы айлдвар ч тэр мөн л нэг байдаг. Энэ учрыг үл ойлгосон явдал нь заримдаа шашин хоорондын зөрчил мөргөлдөөн болон дайн гарахад хүргэдэг байсан. Үнэн бодит байдал бол Бурхан мэдлэгийг мэдлэг хүртэгчдийнхээ ойлгож хүлээж авах боломжийг харгалзан нэг бол шууд Өөрөө эсвэл элч төлөөлөгчөө илгээн шууд бус байдлаар буюу тэд нараар дамжуулан хүртээдэг гэдэгт оршдог.

Янз бүрийн бичээсүүд байдаг нь янз бүрийн ангиллын сонсогчдод зориулагдсан хэрэг.

Бурханлаг талын хөгжил дэвшил бүхий нийгэмд мэдлэгийг цэвэр ариун хэлбэрээр нь хүртээн дамжуулдаг. Харин нийгэм ёс суртахууны болон бурханлаг үнэ цэнэт зүйлсээ алдан гээсэн, хүмүүс амьтадын түвшинд хүртлээ унан доройтсон байх аваас мэдлэгийг, нэг талаас бурханлаг амьдралдаа их биш ч гэсэн хөгжил дэвшил гаргаасай гэж, нөгөө талаас мэдлэгийг гажуудуулан буруу бүү болгоосой гэсэн үүднээс хялбаршуулж тааруулсан хэлбэрээр дамжуулдаг.

Исламын болон Христын шашин нь цаг хугацаа, газар орон болон нөхцөл байдалд таарч, зохицож нийцсэн байдлаар үүсэж бий болсон.

Бурханлаг зам мөрийн зарчмуудыг дагах нийгмийн чадварыг үнэлж цэгнэж үзээд элч нар бурханлаг эрдэм ухааныг тодорхой байдлаар дамжуулан хүртээдэг байсан. Лүндэн буулгагч буюу элч Мухаммед нь Кораны номлол сургаалыг бүрнээ унаж доройтсон хүмүүст хүртээхээр бууж ирсэн гэж бид ойлгож болно. Жишээлбэл, Кораны 16 дугаар Сурад: “Өөрийн ээж болон эгчтэй бүү хурьц.” гэж өгүүлдэг. Мухаммед соёл иргэншилт хүмүүст сургаал номлол хүртээж дамжуулж байсан бол иймэрхүү сургаал номлол илүүц зүйл байх байсан. Бурханыг ухаарсан хийгээд элч болон сонгогдсон сүнс Мухаммед нь нүүдэлчдийн дээрхтэй адил харьцаа, үйлдэл хэвийн үзэгдэл болсон байсан завхран гажуудсан овог аймгийнханд сургаал номлолоо номлож байлаа.

Библид: “Бүү хөнөө.” гэж өгүүлдэг. Бүү хөнөө гэсэн ийм сургаал номлолыг хэнд номлох вэ? Зөвхөн хөнөөгчдөд л. Ийсуc номлол сургаалаа зөвхөн гуравхан жил номлосон. Номлол сургаалаа эхлээд гуравхан жил болж байх үед нь түүнийг цовдолсон. Хамгийн шилдэг сайн шавь нь 30-хан мөнгөн зоосны төлөөнөө түүнээс урвасан, өөр нэг шавь нь түүнийг огт таньдаггүй хэмээн мэлзэж үгүйсгэсэн байх аваас тэднийг эгэл ард түмэн байсан гэдэг тухай юу ярьж болохсон билээ?

Кришна Бхагавад Гита-г хүний бүхий л шилдэг сайн шинж чанаруудын биелэл болсон Арджунад айлдсан билээ. Энэ явдал Энэтхэгийн соёл иргэншлийн цэцэглэл хөгжилтийн үед болсон. Амьдралаа бүхий л хүн төрөлхтөний сайн сайхан, ач тусын төлөөнөө тахилга өргөл үйлдэхэд зориулан байгаа тэвчил хатамжлалт, Наимишараньигийн мэргэдтэй Сута Госвами ярилцаж байгаа тухай Шримад Бхагаватамд өгүүлдэг. Бхагавад Гита болон Шримад Бхагаватамыг сонсож хүртэгчдийн түвшин ийм байсан. Иймээс Бхагавад Гита болон Шримад Бхагаватам нь Библи болон Коранаас ялгаатай гэдэгт гайхаад байх зүйл огт байхгүй.

Шашнууд янз бүр ч айлдвар илгээлт бол бол нэг.

Вьясадева, Ийсус Христос болон Мухаммед нар бол бурханлаг хөгжлийн хувьд нэг адил түвшинд хүрсэн хийгээд бүрэн эрхтэй элч төлөөлөгчид байсан. Гэхдээ бурханлаг оюуныхаа хүчээр тэд үнэнийг нийгмийн хүлээж авч чадах тэр хэмжээгээр л нээн хүртээцгээсэн. Бүхий л ариун гэгээн бичээсүүдийн гол учир утга нь нэг л адил байдаг ба дараахь зүйлд хүргэдэг:

1. Бурхан бол нэг бөгөөд Тэр бол хайр.
2. Бурханы хуулиудыг дуулгавартайгаар дагах.
3. Бурханд үйлчлэн зүтгэх.
4. Бурханы орондоо буцаж очих боломжийг олгох.
5. Нүгэлт үйлээс татгалзах.
6. Ариун гэгээн нэр алдрыг алдаршуулах.
7. Материаллаг таашаал ханамжаас татгалзах.
8. Бурханлаг номлогчыг хүлээн авах.

Хоол хүнсэндээ мах хэрэглэх болон гэр бүл, бэлгийн харьцааны тал дээр тодорхой хязгаар цээр болон дүрэм журмууд шашин бүрт байдаг. Нэг бичээс нь хүнийг дөрвөн эхнэртэй байхыг зөвшөөрч байхад, өөр нэгэн нь эхнэр авахыг ивээнгүйгээр зөвлөдөг, харин гуравдахь нь бэлгийн харьцаанаас бүрмөсөн татгалзахыг номлодог. Нэг бичээс нь хоол хүнсэндээ махыг (гэхдээ гахай болон нохойны биш) тахилга өргөл болгон өргөсний дараагаар хэрэглэхийг зөвшөөрч байхад, нөгөө нь баасан гаригт мах идэхгүй байхыг номлодог, харин гуравдахь нь махнаас бүрмөсөн татгалзахыг зөвлөдөг.

Нэг асуудалд ийм өчнөөн олон янзын загвар, хэв маяг байгааг юу гэж тайлбарлах вэ? Энэ бол тийм хүнд бэрх зүйл биш. Бурханы элч нар нэг л мэдлэгийг агуулж байдаг хэдий ч сонсогчдынхоо хүлээж авч чадах тэр л зүйлийг нь өгдөг. Мухаммед нэг ихийг өгч чадаагүй ч амиа эрсдүүлэх аюулаас айн Мекка-гаас зугатаахад хүрсэн. Номлолоо хийж эхлээд гурван жил өнгөрч байх үед нь Ийсусыг цовдолсон. Библид Ийсус: “Маш ихийг хэлж ярихыг хүсэж байгаа ч даанч та одоо багтаахгүй.” гэж өгүүлдэг нь сонирхолтой хэрэг биш гэж үү? Бхагавад Гита-д Бурхан Кришна Арджунад хандан: “Харин Би одоо чамд энэхүү материаллаг болоод бурханлаг мөн чанарын тухай мэдлэгийн талаар бүхэлд нь тайлбарлая. Үүнийг ойлгож хүртсэнээр чамд таньж мэдээгүй зүйл гэж огт үгүй болно “ (Б.-г.,7.2).

Трансценденталь (бурханлаг) мэдлэг бол бурханлаг ертөнцийн, мөн материаллаг ертөнцийн ч талаарх мэдлэгийг өөртөө агуулдаг. Жишээ нь, бидэнд халаасны жижиг толь бичиг ч байдаг, мөн дэлгэрэнгүй их мэдээллийг агуулсан том хэмжээтэй тайлбар толь ч байдаг. Христын болон исламын зэрэг шашнуудыг үнэнийг нийгмийн хөгжлийн түвшинд нь тааруулж нийцүүлэн хэсэгчилсэн байдлаар багтааж тусгасан халаасны жижиг толь бичигтэй зүйрлүүлж болно. Харин Бхагавад Гита зэрэг тийм ариун гэгээн бичээсүүд нь өөр юуг ч үлдээлгүй, бүхий л мэдлэгийг бүрэн дүүрэн агуулдаг дэлгэрэнгүй том тайлбар толь лугаа юм. “Явах”, “идэх” болон “унтах” гэсэн энгийн үгнүүд нь халаасны жижиг толь бичигт ч байдаг, мөн дэлгэрэнгүй том толь бичигт ч агуулагддаг. Яг үүн лугаа, “Хулгай бүү хий.”, “Ойр дотныхноо хайрла.”, “Дайснаа өршөө.”, “Бусдын төлөө сайн сайхныг хийж үйлд.” гэх зэргийн энгийн үгнүүд нь бүхий л ариун гэгээн бичээсүүдэд байдаг. Харин “эрс эргэлт шинэчлэл”, “урьдаас тогтоогдсон байдал буюу хувь тавилан” зэрэг тийм үгсийг зөвхөн том толь бичгүүд л агуулдаг. Харин “Хольцоогүй цэвэр ариун хайрын улмаас Бурханы таалалд нийцүүлэх”, “Бурханд үйлчлэн зүтгэх, Бурханы тухай хоногийн 24 цагийн туршид бодож санах болон материаллаг таашаал ханамжаас татгалзах”, “Ангижрахыг ч үл эрмэлзэн, Бурханд амьдралаас амьдралдаа үйлчлэн зүтгэх хүсэл” зэрэг цэвэр-цэвэр ариуны хүрээний сэдвүүдийг зөвхөн, санатана-дхарма-г илэрхийлэх хамгийн эрхэм дээд, ариун бичээсүүдэд л олж болно.

Гэхдээ ариун гэгээн бүхий л бичээсүүд төгс төгөлдөр. Исламд суфигийн ариун гэгээнтэнгүүд

хоол хүнсэндээ мах хэрэглэхийг тэвчин цээрлэдэг бөгөөд Кораныг даган баримталдагийнхаа ач тусаар тэд бурханлаг хөгжлийн өндөрт хүрдэг. Христын шашинд францисканы ах дүү нар болон бенедикт-лам нар цагаан хоолны хатуу чанга дэглэм баримталдаг, тэвчил цээрлэл болон эрүүл ухаантай, бодлоготой байдлыг сахьдаг бөгөөд мөн л бурханлаг өндөрт хүрдэг.

Бхагавата-дхарма бол бурханлаг супермаркет.

Эдүгээгийн нийт олны дунд хиндуизм хэмээх нэрээр нэршсэн бхагавата-дхарма нь өөрийн байр, үзэл бодолдоо өнөөг хүртэл гуйвалтгүй зогссоор байна. Олны дунд илүү ихээр түгэн дэлгэрсэн шашнуудын цаг хугацааны түүхийг авч үзвэл: Ислам 1300 жил, Христ 2000 жил, Буддизм 2500 жилийн өмнөөс үүсжээ. Бхагавад Гита-г Арджунад 5000 жилийн өмнө айлдсан. Бурхан түүний 4 дүгээр бүлэгт ийн айлддаг: “Би йогын энэхүү мөнхийн эрдэм ухааныг нарны тэнгэр Вивасванд айлдсан билээ. Харин Вивасван түүнийг хүн төрөлхтний эцэг Мануд, Ману цааш нь Икшвакуд дамжуулан номлосон. Чи Миний чин бишрэлтэн бөгөөд найз нөхөр минь болох учир хийгээд иймээс энэхүү эрдэм ухааны трансценденталь нууц ид шидийг ойлгож хүртэж чадах тул Бүхний Дээдтэй холбогдсон харьцаа холбооны тухай энэхүү өнө эртийн эрдэм ухааныг Би чамд өнөөдөр нээн хүртээж байна.” (Б.-г., 4.1-3).

Бурхан Гита-г Мануг төрөхөөс ч өмнө нарны бурхан Вивасванд айлдсан гэдэг энэ баримтыг анхааралдаа авах аваас Гита бол эхлээд ойролцоогоор 120 40 000 жилийн өмнө айлдагдсан хийгээд хүний нийгэмд 2 сая жилийн тэртээ номлогдсон гэж хэлж болно. 5000 жилийн өмнө Кришна энэхүү бурханлаг мэдлэгийг Арджунад айлдсан. Гита-гийн өөрийн нь агуулга хийгээд түүнийг айлдагч Бурхан Шри Кришнагийн таалал бодлоор бол Бхагавад Гита ийм түүхтэй.

Тэгэхлээр, бхагавата-дхарма бол хамгийн эртний шашин бөгөөд янз бүрийн шашнуудын супермаркет. Шашны энэхүү олон талт байдал нь унан доройтогсгодын ч тэр, мөн бурханлаг талдаа хөгжин дэвжигсдэдийн ч тэр буюу бүхий л хүмүүсийн жам ёсны дур сонирхолд таарч нийцсэн байхуйцаар тэгж бүтээгдсэн.

Матсья Пурана-д өгүүлсэнчлэн, арваннайман Пуранууд байдаг. Тэдгээрийн зургаа нь харанхуй мунхагт оршин байгаа хүмүүст зориулагдан бичигдсэн. Тэдгээр Пуранууд хүмүүсийг Шива болон түүний гэргий Дургад бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхийг уриалдаг. Дараагийн зургаан Пуранууд нь хүсэл тачаалд орших хүмүүст зориулагдсан бөгөөд Брахма болон бусад сахиулсан тэнгэрүүдийг магтан алдаршуулдаг хийгээд тэдгээрт бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байхыг зөвлөдөг. Сүүлийн зургаа нь цэвэр ариунд орших хүмүүст зориулагдсан бөгөөд шууд Бурхан Хари— Кришнад бишрэл хүндэтгэлээ идэрхийлэхийг номлодог.

Ведийн уламжлал соёлд цаг үе бүрт зориулагдсан бичээсүүд байдаг. Тэдгээр бичээсүүд нь цаг хугацааны тодорхой үеүдэд амьдрах хүмүүст зориулагдан, тэдний сайн болон дутагдалтай муу талуудыг харгалзан бүтээгдсэн. Мөн 108 Упанишадууд байдаг. Тэдний дунд Кали-юга буюу бидний одоогийн амьдарч буй энэ цаг үед зориулагдан бичигдсэн нэгэн Упанишад бий. Энэ бичээсийг Кали Сантаран Упанишад гэдэг. Нэр нь өөрөө хүртэл энэ Упанишад бол Калийн далайг гэтлэн туулахад тусладаг гэдгийг зааж байна. Энэ Упанишадад ХАРЕ КРИШНА ХАРЕ КРИШНА КРИШНА КРИШНА ХАРЕ ХАРЕ/ХАРЕ РАМА ХАРЕ РАМА РАМА РАМА ХАРЕ ХАРЕ маха-мантра-г дурьддаг. Бурханы энэхүү 16 нэр алдрыг давтан хэлснээр буюу давтан уншсанаар амьдралын зорилго буюу Бүхний Дээд Бурханыг хайрлах хайранд хүрч болно.

Бхагавад Гита-г Бурхан Кришна Өөрөө Двапара-юга-гийн төгсгөлд айлдсан, иймээс тэр бол эхэлж буй Кали юга-гийнханд зориулагдсан болно. Мөн Шримад Бхагаватамыг тусгайлан Кали юга-гийн хүмүүст зориулан эхлээд Шукадева Госвами өгүүлсэн, харин дараа нь Сута Госвами давтан өгүүлсэн. Кали юга дахь цэцэн мэргэн хүмүүс Кали Сантаран Упанишад, Бхагавад Гита болон Шримад Бхагаватамыг үзэж судлах ёстой. Энэ цаг үе Кали юга-гийн зүгээс бидэнд учруулахаар зэхэх гай зовлонгоос зайлсхийх болон амьдралын зорилго буюу Кришнаг хайрлах хайранд хүрэх арга замыг бид эдгээр бичээсүүдээс олж болно.

Бурханыг янз бүрийн нэрээр нэрлэдэг.

Бурхан— энэ бол дээдийн дээд Амьд оршнол. Түүнтэй харьцуулахуйц хэн ч байдаггүй. Бурханаас илүү аугаа эсвэл ядаж чанарын хувьд ч гэсэн Түүнтэй эн зэрэгцэх тийм хүн гэж байдаггүй. Түүний шинж чанар нэг бүр нь Түүний аль нэгэн нэрд тусгагдсан байдаг. Тухайлбал, хамгийг чадагч

төгс хүчит гэдэг нь Бурхан бүгдийг чаддаг гэдгийг илэрхийлдэг. Бурханд хэмжээлшгүй их боломжууд байдаг, тэдгээрт хил хязгаар гэж үгүй. “Нар”-ыг англиар “сан”, хиндигээр “сурадж”, санскритаар “сурья” гэдэг. Гэхдээ эдгээр хэлээр ярьдаг хүмүүс тэр үгийг хэлж ярьж байх үедээ бүгдээрээ тэрхүү нэг л нарыг санаж боддог. Мөн тэрчлэн, Бурханыг янз бүрийн нэрээр нэрлэдэг. Тухайлбал, Хамгийн чадагч төгс хүчит гэсэн утгатай Иегова, Хамгийн алдар цуут гэсэн утгатай Аллах, Бүхнийг татагч гэсэн утгатай Кришна, Дээдийн дээд цэнгэн жаргагч— Рама.

Бурхан гэж хэн бэ?

Бурханы хамгийн энгийн тодорхойлолт бол: “Бүх зүйл эх аван гардаг Тэр буюу бүх зүйлийн эх булаг, эх үндэс байдаг Тэр.” (Ш.Б., 1.1.1). Бхагаван гэдэг санскрит үгийг Вьясадевагийн эцэг аугаа эх сурвалж Парашара Муни ийн тайлбарладаг: “Бхагаван гэж бүхий л баялгийг, бүхий л хүчийг, бүхий л алдар цууг, бүхий л гоо сайхныг, бүхий л мэдлэгийг болон бүхий л огоорохуйг агуулсан Тэр юм.” Хорвоо дэлхий дээр хүчирхэг, баян гоо үзэсгэлэнтэй, алдар нэр нь цууд гарч түгсэн, мэдлэгтэй хийгээд огоорсон маш олон хүмүүс байдаг, гэвч тэдний хэн нь ч “Би бол бүх баялгийг, бүх хүчийг... бүрнээ огоорсон.” гэж зарлан тунхаглаж чадахгүй билээ. Дээр дурьдсан эрхэм сайхан чанаруудыг бүгдийг нь төгс төгөлдөр байдлаар агуулдаг Тэр л аяндаа бүгдийг Өөртөө татна. Бүхнийг татагч гэдэгтэй утга нэг санскрит үг бол Кришна.

Библьд Ийсус өөрийгөө Бурханы хүү, Бурханы элч төлөөлөгч гэж тунхагладаг. Коранд Мухаммед өөрийгөө Бурханы лүндэн буулгагч буюу элч гэж нэрлэдэг. Гэхдээ тэрхүү Бурхан гэж хэн бэ? Зөвхөн Тэр л энэхүү асуултын хариултыг төгс мэднэ, иймээс бид үүнийг Түүнээс, Өөрөөс нь мэдэх ёстой. Ведийн бүхий л бичээсүүдийн хамгийн алдартай нь болох Бхагавад Гита-гаас бид, Кришна бол Бурханы Дээд Бодьгал гэж мэдэж авч болно. Өөрийгөө бүхий л сахиулсан тэнгэрүүдээс давуу, илүү давамгай гэдгийг Тэр мөн тэнд айлддаг.

Бурхан Бодьгал уу?

Тодорхойлолтоор бол Бурхан төгс төгөлдөр хийгээд Өөрөө Өөртөө дүүрэн ханамжтай. Бурхан бол бодьгал байж таарахгүй гэж ярьж байгаа хүн Дээдийн Дээдийг дутуугаар ойлгож, Түүнийг хязгаарлагдмал юм шиг тийм байдалд оруулж байгаа хэрэг. Бурхан дүр хэлбэргүй буюу Өөрийн бүтээлээс бага, дутуу байдаг байх аваас Түүнийг төгс төгөлдөр гэж нэрлэх аргагүй. Бүрэн Бүтэн бол бидний мэдрэхүйн хүрээ хязгаарын дотор оршихыг ч, мөн түүний гадна оршихыг ч, бүгдийг нь агуулдаг, тийм бус байх аваас Түүнийг Бүрэн гэж нэрлэх аргагүй. Өө сэвгүй хийгээд бүрэн дүүрэн Бурхан Бодьгал байж чадна, гэхдээ Тэр Өөрийгөө Бодьгал байдлаар илрүүлж тодруулахгүй байж ч чадна. Шримад Бхагаватамын дагуу бол Бурхан: Брахман, Параматма болон Бхагаван гэсэн гурван төлөвт оршдог. “Эрдэм мэдлэгтэй мэргэд нь Үнэмлэхүй Үнэнийг Брахман, Параматма болон Бхагаван гэсэн гурван төлөвт таньж мэддэг.” (Ш.Б. 12.11).

Брахман бол нарны гэрэлтэй буюу нарны энергитэй зүйрлүүлж болох бодьгал бус брахмаджьоти юм. Жирийн сурагчид нарны гэрлийг, бүгдэд нэвчин түгэн тархдаг түүний мөн чанарыг болон туяаг ойлгож ухаарсандаа ханамжтай болдог, ханадаг. Брахманыг ухаарсан хүн үүн лугаа байдалтай байдаг. Энэхүү брахмаджьоти бол Бурханы трансценденталь биеэс гарч байгаа туяа бөгөөд үүнийг гьяни нар таньж мэддэг.

Параматма бол Бурханы бүхэнд нэвчиж түгэн байршдаг төлөв бөгөөд атом бүрт, мөн амьд оршнол бүрийн зүрхэнд залран байдаг. Хэрвээ сурагч хүн хичээл чармайлт гарган цааш үргэлжлүүлэн суралцах аваас нар бол бөөрөнхий хэлбэртэй гэдгийг ойлгох хийгээд толинд тусгах нарны дүгрэг дүрсийг харах болно. Параматмаг ойлгож ухаарагчийн түвшин ийм байдаг. Бясалгал үйлдсэнийхээ үр дүнд йогч энэхүү дөрвөн мутартай Вишну (Кришнагийн хувилгаан дүр)-г зүрхэндээ харж эхэлдэг.

Бхагаван бол Үнэмлэхүй Үнэний бүрэн дүүрэн илрэл тодрол бөгөөд Трансцендентальд хүрэх сүүлчийн алхам, шат юм. Бурханы Бодьгалын шинж чанарыг ухаарсан хүмүүсийг нарны гаригийн бүр зүрхэнд нь орж хүрсэн хүнтэй зүйрлүүлж болно. Бхагаван төлөв нь гурван газраараа нахилзсан Кришнагийн хоёр мутартай гоо сайхан дүр (Шьямасундара)-ээр илэрдэг. Бхагаваны шинж чанаруудыг ухаарахуй нь Брахманы болон Параматмагийн шинж чанаруудыг ухаарахуйг өөртөө мөн давхар агуулдаг. Нарыг ядаж нэг удаа ч гэсэн харсан байх аваас та бүхэн тэр бол нарны гэрлийн болон толинд тусан харагдах тусгал дүрсийн эх булаг мөн гэдгийг ойлгож мэдэх болно.

Бурхан бол хүнтэй төстэй хэлбэр дүртэй гэж Библид өгүүлдэг. Ахуй номын 18 болон 19 дүгээр бүлэгт, Тэрээр Израйлевын ард түмний эцэг Авраамын өмнө хүний дүртэйгээр зогсож багйаа тухай өгүүлдэг, гэхдээ энэхүү дүрийн талаар дэлгэрэнгүйгээр тодорхойлон өгүүлдэггүй. “Түүний хөлийн доор” (Эхлэл, 24.10), “Бурханы хуруугаар бичигдсэн” (Эхлэл, 31.18), “Бурханы мутар” (Эхлэл, 9.3), “Бурханы мэлмий” (Ахуй ном, 38.7), “Бурханы чих” (Тоо ном, 11.1) зэрэг илэрхийллүүдийг бид Библиээс мөн олж үзэж болно. Бурханы талаар Ийус, Түүнийг Абба буюу Эцэг гэж нэрлэн ярьж байсан ба Түүнд маш бодьгал байдлаар хандаж байсан. Бурхан бол хэлбэр, дүртэй гэж исламын ид шидтэнгүүд мөн л ярьдаг. Дээр өгүүлсэнчлэн, Библиүүд Бурханы тухай мөн л Бодьгал байдлаар өгүүлж байна. Тийм бус байсан бол бодьгал бус Бурханд яаж хөл, хуруу, мутар, мэлмий болон чих байж таарах билээ?

Библи болон Коранаас ч маш эрт, бурханлаг соёлын цэцэглэл мандалтын үед бүтээгдсэн Ведүүд нь Бурханы дүр, Түүний шинж чанарууд, Түүний үйлүүд болон Түүний Бодьгалыг бидэнд нээн хүртээдэг. Мэдээж хэрэг Бурхан бол тоо томшгүй, хэмжээ хязгааргүй олон шинж чанаруудтай бөгөөд үгсийг ашиглаад Түүний алдар цууны талаар зөвхөн бүүр түүр, бүдэг бадаг ойлголт төсөөллийг л өгч чадна. Бурханы дүр бол биднийхтэй адилгүй, Тэр бол яс, булчин болон ялгадасаас бүрдэх материаллаг бие махбодь биш. Бурханы дүр бол материаллаг мэдрэхүйгээр ойлгож хүлээж авах аргагүй трансценденталь, тийм хэдий ч Тэр бол дүртэй.

“Мөнх байдал, мэдлэг болон цэнгэл жаргалын биелэл дүртэй Бурхан Кришнагаас би залбиран гуйж байна.” (Гопал Тапани Упанишад 1.1-1.2).

Брахма-самхитагийн эхний шүлэгт: “Кришна бол дээдийн дээд Хяналт тавигч, Тэр бол мөнх байдал болон цэнгэл жаргалын биелэл болсон дүртэй. Тэр бол бүх учир шалтгааны эх учир шалтгаан” гэж өгүүлдэг.

Мөн тэнд өгүүлсэнчлэн, “Анхдагч Бурхан, Говиндад бишрэл хүндэтгэлээ би илэрхийлнэм Сарны зүүлтээр чимэглэгдсэн Түүний хүзүүнд цэцэгсийн хэлхээ зүүлттэй байна. Түүний мутрыг лимбэ болон үнэт эрдэнийн чулуун бугуйвчнууд чимэглэнэ. Тэрээр хайрын цэнгээн наадмаар үргэлжид баясан цэнгэнэ. Түүний гурван газраа нахилзан туялзаж байх Шьямасундара гоо сайхан дүр мөнхөд оршин байдаг.”

Бурханы дүрийн талаарх дээрхтэй төстэй тодорхойлолтууд олон байдаг. Тэрхүү дүр эгэл жирийн амьд оршнолуудын материаллаг бие махбодиос огт өөр, ялгаатай. Бидний бие махбодь бол зуурдын хийгээд харанхуй мунхаг байдлаар дүүрэн, тэр бол бидний зовлон шаналалын учир шалтгаан. Кришнагийн, мэдлэг болон цэнгэл жаргалын биелэл болсон хийгээд мөнх биеийн жинхэнэ мөн чанарыг ойлгоход Шримад Бхагаватамын дараахь жишээ туслана. Бурхан Кришнагийн газар дэлхий дээрх ээж Яшода шавар идсэн эсэхийг нь шалгахаар Түүний амыг ангайлган хардаг. Эгэл жирийн хүний амруу харах аваас тэнд зөвхөн хэл, шүд болон буйл л харагдах болно. Гэтэл, бяцхан Кришнагийн амыг ангайлган харах үедээ Яшода ээж тэнд бүхий л орчлонг хардаг. Орчлон дотор Кришнагийн амруу харж байгаа өөрийгөө хүртэл олж үздэг. Хэдийгээр Кришна Яшодагийн өмнө бяцхан хүү байдалтай зогсож байгаа ч үүнтэйгээ нэгэн зэрэг Тэрээр бүхий л орчлонг Өөрийн дотор агуулж тээж байдаг гэдгийг энэ жишээ харуулдаг.

Бурханыг хайрлах хайрын балтай савыг нээн онгойлгосон хийгээд энэхүү хайрыг бүгдэд, хэн бүрт түгээн тараасан Бурханы өршөөлт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада өөрийн номууддаа “Бурхан” гэдэг үгийн оронд Бүхний Дээд Бурханы Бодьгал гэдэг үгийг хэрэглэсэн байдаг. Эдгээр үгнүүд нь дүр хэлбэр болон бодьгал байдлыг илэрхийлдэг. Бурханы Бодьгал (том үсгээр бичигдсэн) гэдэг нь Кришна бол жижиг үсгээр бичигддэг бүхий л бурхадын дээр залардаг гэсэн үг юм.

Материаллаг мөн чанар, цаг хугацаа ба карма.

Шри Кришна бол бусад бүхий л амьд оршнолуудыг Хянан захирагч, дээдийн дээд Цэнгэн жаргагч. Материаллаг мөн чанар буюу байгаль бол Түүний эрчим. Бие даан орших амьд оршнол бол Түүний бурханлаг (дотоод) эрчмийн жижигхэн хэсэг. Харин материаллаг мөн чанар бол Түүний гадаад эрчим юм. Энэхүү эрчим нь цэвэр ариун, хүсэл тачаал болон мунхаг харанхуй гэсэн гурван гуна буюу шинж чанар хийгээд шороо, ус, гал, хий, огторгуй, ухаан, оюун болон хуурмаг эго гэсэн найман элементүүдээс тогтдог. Эдгээр гунууд нь цаг хугацаа (Кришнагийн бас өөр нэг эрчим)-ны хяналтын доор хоорондоо янз бүрийн байдлаар тааран нийлцгээх бөгөөд ингэснээр үйл ажиллагаанууд дагалдах үр дагавруудын хамтаар төрж бий болдог.

Материаллаг мөн чанарын гурван гунууд.

“Туна” гэдэг үгийн нэг утга нь уяа. Нарийн цуулсан гурван хэсэг материалыг нийлүүлэн томж эсвэл сүлжин уяа хийдэг. Эхлээд цуудсан материалаа бэлтгээд гурван хэсэг болгодог, тэгээд тэдгээр гурван хэсэг тус бүрээ эрчилдэг. Эцэст дээрх эрчилсэн гурван хэсгээ нийлүүлэн томдог. Ингэснээр уяа маш бат бөх болдог. Мөн үүн шиг, материаллаг мөн чанарын цэвэр ариун, хүсэл тачаал болон харанхуй мунхагийн гунууд өөр хоорондоо холилдож нийлэлдэн янз бүрийн дагалдах бүтээгдэхүүнүүдийг бий болгодог. Дараа нь тэдгээр холилдсон байдалтай байгаа бүтээгдэхүүнүүд нь мөн л өөр хоорондоо холилдон нийлдэг, ийм үйл явц дахин дахин болж явагддаг. Үр дүнд нь, өөр хоорондоо тоо томшгүй олон удаа сүлжилдсэн гунуудаас бүрэлдэн тогтсон бат бөх уяа бий болдог.

Материаллаг эрчим нь биднийг ийм байдлаар улам бүр их хүчтэйгээр уяж хүлдэг. Бид өөрийн хүчээр эдгээр хүлээснүүдээс салж чөлөөлөгдөж чадахгүй. Эдгээр уяа хүлээснүүдийг дараах байдлаар тодорхойлж болно:

- 1) Нөр шаргуу хөдөлмөр: Энэ ертөнц дэх амьд оршнол бүр амьд мэнд байх хийгээд амьдралаа тэтгэн тогтоох буюу залгуулахын тулд нөр шаргуугаар тэмцдэг. Үүнийг амьдралын төлөөний тэмцэл гэж нэрлэдэг.
- 2) Хөөс: Хүнд хэцүү ажилд зүтгүүлсэн морины аманд хөөс цахардаг. Яг л үүнтэй адилаар, мэдрэхүйдээ таашаал ханамж эдлүүлэхийн төлөөнөө хүнд бэрх ажилд зүтгэн байх үед бидний ам хуурайшин хөөс гарч эхэлдэг.
- 3) Боолчлогдол: Бид бүх талын хүчин чармайлт гаргасаар байсан ч материаллаг мөн чанарын гунуудын уяанд хүлэгдсэн хэвээр байдаг.
- 4) Айдас хүйдэс: Материаллаг амьдралаар амьдарч байгаа хүн дараагийн агшинд юу болж тохиолдохыг үл мэдэх учраас үргэлж л айдас хүйдэст автан байдаг.
- 5) Үхэл: Энэ ертөнцөд аз жаргалтай байх гэсэн хүний төлөвлөгөө болон горьдлого найдварыг нь үхэл таслан зогсоодог.

Цэвэр ариун, хүсэл тачаал болон харанхуй мунхагийн гунуудад оршин байгаа хүмүүсийн шинж чанарууд.

Цэвэр ариуны гунын нөлөөн дор хүн бусдаас илүү цэцэн мэргэн болдог. Ийм хүн амьдралаа ведийн сургаалд заасны дагуу зохион явуулдаг болохоор аз жаргалгүй байдал буюу гуниг гутрал, зовлон шаналал бусад хүмүүсийг салахгүйгээр даган байдаг шигээр түүнийг дагадаггүй. Тэрээр материаллаг мэдлэгт ахиц дэвшил гаргаж байгаагаа мэдэрдэг. Ийм хүн нүгэлт үр дагавраас их бага ямар нэгэн хэмжээгээр салж холдсон байгаа учраас өөрийгөө аз жаргалтайгаар мэдэрдэг. Цэвэр ариунд батжин бэхжсэн хүнд, тэрээр бусдаас олон талаар илүүтэй давуутай, сайн болсон байгаа юм шиг санагдаж, харагдаж эхэлдэг. Энэ тал дээр тохирох хамгийн сайн жишээ бол: яруу найрагчид, философичид болон эрдэмтэн мэргэд. Тэд өөрсдийн мэдлэгээр машид бардамнан бахархдаг. Ийм хүмүүс харьцангуй амар мэнд, элбэг дэлбэг байдалд хүрдэг учраас өөрсдийгөө аз жаргалтай байгаа мэтээр боддог. Аз жаргалтай байхуйн энэ мэдрэмж нь тэднийг цэвэр ариуны гунаатай уядаг.

Хүсэл тачаалын гуна дахь хүн материаллаг тал дээрээ ханамжтай байхыг шунан дурладаг. Ийм хүн таашаал ханамж эдлэхийг шунадаг ба амьдралын утга учир үүнд л байдаг гэж үздэг. Мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн тулд хүн нийгэмдээ зарим талаар хүндлэгдэж, аз жаргалтай гэр бүлтэй байхын зэрэгцээ материаллаг талдаа элбэг хангалуун байх ёстой. Үүнийг хүсэж байгаа бол хүн нөр шаргуугаар ажиллаж хөдөлмөрлөхөөс өөр аргагүй байдалд тулгагдан ордог. Учир нь юу вэ гэвэл, орон байр, гэр бүл болон алдар хүндтэй байхын тулд байнгын дэмжлэг тулгуур хэрэгтэй. Хүсэл тачаалын гуна дахь хүний үйл ажиллагаа үр дүнд хүрэхийн төлөөнөө чиглэгдсэн байдаг. Ийн зүтгэж байгаа хүн мөнгө хөрөнгийг өчнөөн төчнөөгөөр нь олж байж болох, тэгээд түүнийгээ өөрт хэрэгтэй гэсэн зорилгодоо зарцуулдаг. Заримдаа тэрээр нийгэм дэх өөрийн алдар хүндээ дээшлүүлэхийн төлөөнөө эмнэлэгийн байгууллагууд барьж байгуулах, өглөг тусламжийн үйлд зориулах гэх мэт зүйлд олсон мөнгө хөрөнгөө зарцуулдаг. Ийнхүү орчин үеийн материаллаг дэлхий их эсвэл бага ямар нэгэн хэмжээгээр чухамхүү энэ гунагийн нөлөөн доор оршдог. Харин урьдын цагт ведийн нийгэмд цэвэр ариуны гуна зонхилж байсан.

Харанхуй мунхагийн гуна бол цэвэр ариуны гунагийн яг эсрэг байдал. Энэ гунад орших хүмүүс юмсын жинхэнэ учир утгыг ойлгодоггүй. Энэ гуна дахь хүмүүс маш залхуу хойрго бөгөөд

бурханлаг амьдралыг огтхон ч сонирхдоггүй. Хүсэл тачаалын гуна дахь идэвхтэй байдал түүнд байдаггүй. Ийм хүн шаардлагатай хэмжээнээс илүү их хугацаагаар унтдаг. Бие организмыг эрүүл саруул байлгахад зургаан цагийн нойр л хангалттай, гэвч харанхуй мунхаг дахь хүмүүс 10-12 цаг унтдаг. Ийм хүмүүс байнгад гутранги, уруу царайтай явдаг. Тэд нойр болон мансуурах зүйлд дурлан татагддаг. Тэдний хийж үйлдэж байгаа аливаа үйл ажиллагаа нь тэдэнд өөрсдөд нь ч тэр, мөн ойр тойрныхонд нь ч тэр ач тус авчирдаггүй.

Дээрхийн аль нэгэн байдлаар хийж үйлдэхийг бидэнд юу тулгадаг вэ?

Хийж үйлдэж байгаа бүх үйлээ бид өөрсдөө хянадаг ба бүх шийдвэрээ өөрийн сэтгэл зорилгод таарч нийцсэн байдлаар гаргадаг гэж дийлэнх хүмүүс боддог. Гэхдээ энэ бол тийм биш, бид бол байгалийн хүчний гарт дахь зүгээр л хүүхэлдэйнүүд бөгөөд энэ тухай Кришна Бхагавад Гитагийн 3.5-д ийн айлддаг: “Амьд оршнол бүр нь материаллаг мөн чанарын гунуудын нөлөөллөөс төрөн гарах даралт шахалтын дагуу үйл үйлдэхээр тулгагдсан ямар ч арчаагүй байдалтай байдаг. Иймээс хэн ч, хоромхон зуур ч үйл үл үйлдэн зүгээр байна гэж байдаггүй.”

Цэвэр ариуны гунад оршин байгаа хүмүүсийн амьдрал аз жаргалаар дүүрэн мэт харагдаж байж болох ч тэд тэртэй тэргүй л бие махбодийн амьдралын үзэл бодлоор болзолдож нөхцөлдсөн хэвээр байдаг, иймээс тэд хий хуурмаг байдалд оршдог. Хэн нэгэн нь, би бол мистер Х, америк хүн, дунд хир насны эрэгтэй, үнэнч нөхөр, халамжтай сайн эцэг, оюунлаг, боловсролтой джентльмен... гэх зэргээр бодож байж болох. Гэхдээ эдгээр нь зөвхөн бие махбодь болон ухаанд л хамааралтай учраас бүгд материаллаг шалгуурууд юм. Тэрээр өөрийгөө бие махбодь эсвэл ухаан биш, харин Кришнагийн мөнхийн албат, сүнс гэж ухаараагүй хэвээр л явдаг. Өөрийгөө бие махбодь хэмээн үзэж байгаа цагт тэрээр байгалийн хуулиудын нөлөөн дор байгаа хэвээр байх бөгөөд төрөлт, хөгшрөлт, өвчлөл болон үхэлтэй холбогдсон зовлон шаналалыг туулж эдэлсээр л байх болно.

Цэвэр ариуны гунад оршин байгаа хүн ийм байдлаар уягдаж хүлэгдсэн байдалтай байдаг бол хүсэл тачаал болон харанхуй мунхагийн нөлөөн дор байх бусдын тухайд гэвэл юу ярих билээ? Хүсэл тачаалын гунын нөлөөн дор орших хүн тоо томшгүй олон хүслүүдээ хангах гэсэн оролдлогуудад уягдаж хүлэгдсэн байдаг бол харанхуй мунхагт оршигчид нь ухаангүй байдал, залхуу хойрго болон нойрмог байдлаар уягдаж хүлэгддэг.

Мөнх байдал, мэдлэг болон цэнгэл жаргалаар дүүрэн бурханлаг амьдрал бол бидний жинхэнэ амьдрал. Цэвэр ариуны хий хуурмаг байдалд дур булаагдан сэтгэл татагдсан хүмүүс нь материаллаг боловсрол болон материаллаг элбэг дэлбэг, амар мэнд байдалд хүрэх явдлыг амьдралын жинхэнэ зорилго гэж үздэг. Хүсэл тачаалын гуна дахь хүмүүсийн хувьд сексийн таашаал ханамж эдлэх болон эд хөрөнгө хуримтлуулах явдал бол цорын ганц бодит зүйл нь байдаг, харин харанхуй мунхагийн гунад оршигчдын хувьд бол нойр болон мансууруулах зүйлс. Бидний цэвэр, ариун бурханлаг мөн чанар ийм байдлаар материаллаг мөн чанарын гунуудын төрж бий болж байгаа цэвэр, ариун бус хүслүүдээр бузартаг.

Кришна бол сварат буюу бүрнээ үл хамааралтай. Тэрээр таалан хүсэж байгаа бүхнээ хийж чадах билээ. Түүний маш өчүүхэн жижиг хэсэг мөн болох бид үл хамааралтай байх шинж чанарыг мөн л агуулдаг, гэхдээ өчүүхэн бага хэмжээгээр. Иймд хүслүүд маань материаллаг байгаа болохоор тэдгээр хүслийн дагуу бидний бие махбодь нэг бол цэвэр ариуны, хүсэл тачаалын эсвэл харанхуй мунхагийн гунад эсвэл тэдгээрийн холилдсон төлөв байдалд үйл хөдлөлөө хийдэг. Бидний ийм хүслүүд бол бид өөрсдийгөө материаллаг бие махбодьтойгоо адилтган үздэгийн үр дүн, иймээс эдгээр хүслүүд бол материаллаг мөн чанарын гунуудын бүтээгдэхүүн юм. Эдгээр хүслүүдээ хангах гэж замнан байгаа бидний замууд ч гэсэн мөн л материаллаг.

Кармын хуулиуд: Алдаа эндэл үл гаргадаг хууль зүй.

Дахин төрөлтийн механизм.

Бие даасан амьд оршнол бол бүдүүн болон нарийн гэсэн материаллаг хоёр бие махбодь дотор оршдог. Дотор нь сүнс оршин байдгийн ачаар эдгээр бие махбодиуд үйл ажиллагаа хийж үйлддэг хийгээд хөгждөг. Түүнээс гадна тэдгээр нь мөнхийн сүнсний түр зуурын бүрхүүлүүд бөгөөд эхлэл болон төгсгөлтэй. Параматмагийн нарийн чанд хараан дор үйл хөдлөлөө хийж явуулдаг байгалийн хатуу чанд хуулиудын хяналт дор тэд үргэлж байдаг. Бүдүүн бие махбодь хөгширч доройтох хийгээд

хэрэггүй болох цагт сүнс нарийн бие махбодийн хамтаар түүнийг орхидог. Энэ үйл явцыг ерөнхийдөө үхэл гэж нэрлэдэг. Сүнсийг дагалдан байгаа нарийн бие махбодь амьд оршнолын бүхий л бодол болон хүслүүдийг үхэл болон дараагийн төрөлт хоёрын хооронд агуулан байдаг бөгөөд чухамхүү тэдгээр бодол, хүслүүд л тэрхүү амьд оршнол дараагийн төрөлдөө ямар хэлбэрийн бүдүүн бие махбодь авахыг тодорхойлдог. Амьд оршнол ийнхүү кармын хууль болон Параматмагийн удирдлага дор өөрийн ухааны шинж маягт таарч нийцсэн бие махбодид ордог. Энэхүү сэлгэлтийг бид төрөлт гэж нэрлэдэг. Үхэх мөчид нарийн бие махбодь сүнсийг өөр бүдүүн бие махбодид зөөн оруулдаг. Энэ үйл явц нь агаар үнэрийг хэрхэн зөөдөгтэй төстэй юм. Сарнай цэцгийн үнэр хаанаас гараад байгааг бид хардаггүй, гэхдээ түүний үнэрийг салхи зөөн ирж гэдгийг мэддэг. Үүн лугаа, сүнсний шилжилт сэлгэлтийн үйл явц бол ойлгож мэдэхэд хүнд бэрх. Бие махбодийн үхэх үе дэх ухамсрын түвшиндээ харгалзсан байдлаар сүнс эцгийн үрээр дамжигдан тодорхой эхийн хэвлийд ордог, тэгээд түүнд эхийн нь өгч байгаа тэр бие махбодь хөгждөг. Энэ нь хүний бие махбодь ч байж болно, эсвэл муурны эсвэл нохойных ч гэх мэт... байж болно. Дахин төрөхүйн үйл явц ийм байдлаар болж явагддаг.

Сүнсний хүслүүдэд таарц нийцсэн байдлаар “эсгэгдсэн” бие махбодь.

Зах дээр цамц, өмд, футболк, джинс гэх мэтээр олон янзын зүйлс дэлгээстэй, өрөөстэй харагддаг. Яг л үүн лугаа, бидэнд амьдралын 8 сая 400 мянган хэлбэр буюу бие махбодийн ийм өргөн сонголт байдаг. Хүслүүдээ биелүүлэхийн тулд бид тэдгээрээс дуртайгаа авч болдог. Жишээлбэл доорхи хүслүүдийн аль нэг нь Танд байна гэж үзье.

1. Та их унтах дуртай юу? Тийм бол Та цагаан баавгайн бие махбодид төрөн, жилийн 6 сарын туршид унтана. Таныг найз нөхдүүд чинь шоолохгүй, эцэг эх чинь загнахгүй.
2. Та мах идэж, цус уух дуртай юу? Тийм бол байгаль Танд: “За тэгвэл, урагшаа! Бар эсвэл арслангийн бие махбодид ор!” гэж хэлж өгөх болно.
3. Та өдөржингөө усанд шумбах, сэлэх дуртай юу? Загасны бие махбодийг аван төрөөд хичнээн л бол хичнээн, дураараа сэлэх болно.
4. Зарим хүмүүс амьдралынхаа ихэнх цаг хугацааг онгоцонд өнгөрүүлдэг. Байгаль: “Шувууны бие махбодийг аван төр, ямар ч аюул осол гарахгүй, замаас гажиж байна гэх зүйл огт байхгүй байна!” хэмээн хэлэх болно.
5. Зарим хүмүүс эсрэг хүйстнийхээ анхаарлыг татахаар бие махбодио нүцгэлэн харуулж үзүүлэх дуртай байдаг. Ийм тохиолдолд байгаль: “Модны бие махбодийг ав! Тэгээд жилийн ямар ч цаг улиралд баяр хөөртэйгээр зогс!” гэсэн саналыг дэвшүүлдэг.

Амьдралын ямар ч хэлбэр байлаа гэсэн амьд оршнолд “Хүслээ биелүүл!” хэмээн баяр хөөр таашаал ханамжийн тодорхой хэлбэрийг өгдөг, хангадаг.

Амьд оршнол бүр сварупа буюу бурханлаг хэлбэртэй байдаг бөгөөд энэ нь түүний бурханлаг ертөнц дэх мөнхийн хэлбэр юм. Энэ хэлбэр нь амьд оршнолыг нэг бие махбодиос нөгөө бие махбодид шилжин явах үед өөрчлөгддөггүй. Жишээ нь, мэс засал хийх, утасны шон босгох, бокс тоглох гэх мэт болон өөр бусад янз бүрийн ажил үйл хийхдээ хүн гараа ашигладаг, гараараа хийдэг. Эдгээрийн аль тохиолдол нь байлаа гэсэн хүн хийх гэж буй тухайн үйлдээ таарч зохицсон бээлий өмсдөг. Гэхдээ түүний гар өөрчлөгддөггүй. Үүн лугаа, сүнс нэг бие махбодиос нөгөө бие махбодид шилжин орж байлаа ч түүний бурханлаг хэлбэр өөрчлөгддөггүй, хэвээр үлддэг.

Ямар нэгэн бие махбодийг аван төрөхөд кармын нөлөөлөх үүрэг роль.

Нарийн бие бол ухаан, оюун болон хуурмаг эго-ноос бүрддэг. Дахин төрөх үйлийн явцад амьд оршнол нь нарийн бие махбодьтойгоо кармын хуулийн дагуу шилждэг. Карма бол амьд оршнолын материаллаг мөн чанарын гурван гунын нөлөөн дор оршин байгаа хийгээд цаг хугацааны явцад урсан байгаа түүний сэтгэл хүслийн дагуух үйл ажиллагаа юм.

Амьд оршнолын үйлдэж байгаа аливаа үйл ажиллагаа хариу үйлдлийг төрүүлж гаргадаг. Жишээ нь, боловсролын хэрэгцээнд зориулан өглөг хандив өгч байгаа хүн дараагийн амьдралдаа маш чинээлэг хүн болох бөгөөд сайн боловсрол эзэмшинэ. Нөгөө талаас, эмэгтэй хүн үрээ хөндүүлэх аваас дараагийн амьдралд нь түүнтэй төрөөгүй хүүхдэд нь учирч байсан тийм хувь тавилан тохиох болно. Амьд оршнол материаллаг мөн чанарын гунуудын нөлөөн дор оршин байгаа цагт кармын хуулийн дагуу амьдралын янз бүрийн хэлбэрүүдэд байнгад дахин төрсөөр байх болно. Сүнс

материаллаг бие махбодиос гарч байгаа үед түүний хүслүүд ухаанд нь хадгалагдан үлддэг учраас энэ нь үнэн хэрэгтээ байгалийн дээд хуулиудын (Тэдгээрт мөн кармын хууль хамаарагдана.) дагуу амьд оршнол эдгээр хүсэл төлөвлөгөөнүүдээ амьдралд шинэ бие махбодтойгоор хэрэгжүүлэх боломжийг хүртэж байгаа хэрэг юм. Ухамсарын янз бүрийн түвшингүүдэд таарч тохирсон амьдралын биологийн ийм олон хэлбэрүүд байдаг гэдэг учир баримтыг энэ явдал тодорхой болгодог.

Сайн карма болон муу карма.

Нэгэн өдөр хоёр хүү төрсөн байг. Нэг хүүгийн эцэг, эх баян бөгөөд боловсрол сайтай хүмүүс. Тэд анхны хүүхдээ төрөхийг олон жилийн өмнөөс л тэсэж ядан хүлээж байсан бөгөөд ийм гайхамшигтай— эрүүл саруул, ухаантай хийгээд дур булаам хүүхэдтэй болсондоо маш их аз жаргалтай байв. Түүний ирээдүй гайхалтай сайн байна гэдэг эргэлзээгүй хэрэг. Нөгөө хүү огтын өөр нөхцөл байдалд байв. Эхийг нь жирэмсэн байхад нөхөр нь хаяад явсан байжээ. Тэрээр ядуу тарчиг, иймээс хүү төрсөн нь тийм ч их баяр хөөр, аз жаргалыг авчраагүй. Ирээдүйд хүндрэл бэрхшээлтэй асуудлууд ихээхэн гарна, учирна гэдгийг эх ойлгож байв. Хорвоо дэлхий иймэрхүү тэгш бус байдлаар дүүрэн. Тийм болохоор л: “Бурхан яаж ийм хатуу ширүүн байж болж байгаа юм бэ? Ямар хатуу хүнд хувь заяа вэ? Х болон Ү хоёрын хүү яагаад сохор төрж байгаа юм бэ? Тэд муу зүйл огтхон ч хийдэггүй хүмүүс шүү дээ. Бурхан шудрага бус хандаж байгаа юм биш үү?” гэсэн асуултууд байнга гардаг.

Гэхдээ дахин төрөхүйн зарчим нь юмсыг илүү алсын хараатайгаар буюу өөрөөр хэлбэл мөнх байдлын байр сууринаас харах боломжийг бидэнд олгодог. Энэхүү амьдрал маань эхнийх ч биш, мөн сүүлчийнх ч биш, энэ бүгд бол мөнх байдалтай харьцуулахад зөвхөн нэгээхэн агшин төдий л юм гэдгийг бид ойлгоно. Иймээс маш их буянтай хүн энэ амьдралдаа зовж шаналж байх аваас тэрээр урьд өмнөх амьдралдаа хийж үйлдсэн гэм нүгэлт үйлийнхээ үр дагавар буюу хор уршгийг амсаж эдэлж байгаа хэрэг гэдэг нь лав.

Үнэн, шудрага байхуйн орчлонгийн энэхүү хуулийг ойлгосноор бид амьд оршнол бол үйлдсэн кармынхаа буюу үйлийнхээ хариуцлагыг зөвхөн өөрөө л үүрдэг гэдгийг мэдэх болно. Дахин төрөхүйн хууль нь амьд оршнолд хүртэх ёстой тэр л хувь тавиланг нь ноогдуулж хүртээхээр үйлчлэл нөлөөллөө огтын алагчлалгүй буюу бүрнээ шудрагаар үзүүлдэг.

Ямар машин худалдаж авах вэ? хэмээн хийх сонголт нь тухайн хүний дур сонирхол болон санхүүгийн боломж дээр үндэслэгддэгтэй яг адилаар материаллаг мөн чанар буюу байгаль нь бидний хүслүүд болон үйлүүдэд тааруулж тохируулан ирээдүйн буюу дараагийн амьдралд маань зориулан бидэнд бие махбодийг сонгож өгдөг. Хэрвээ хүн өөрийгөө ухаарахуйд л зориулагддаг хүмүүний үнэ цэнэтэй амьдралаа хоол, нойр, бэлгийн таашаал ханамж эдлэх болон бие махбодийн аюулгүй байдлаа хангахын төлөөнөө үрэн таран хийх аваас Бурхан түүнд иймэрхүү таашаал ханамжийг бэрх төвөгтэй хязгаарлалтгүйгээр болон хүнд хэцүү үүрэггүйгээр эдлэх ихээхэн боломж бүхий бие махбодид төрөх соёрхлыг хүртээдэг. Шагнал болон шийтгэлийн энэхүү эвлэрэнгүй систем нь эхлээд харахад аягүйцмээр, цочирдмоор санагдаж байж болох ч энэрэл нигүүлслээр дүүрэн дээдийн дээд Амьд оршнол— Бурханы таалал үзэл бодолд бүрнээ таарч нийцдэг. Өөрийн сонголтоор мэдрэхүйн объектуудыг таашаан ханамж эдлэхийн тулд амьд оршнол таарч тохирсон бие махбодтой байх хэрэгтэй. Авахыг эрмэлзэн, шунаж байсан бие махбоддоо амьд оршнол орсон байгаа явдал нь тухайн тэр бодьгалын хүслийн жинхэнэ биелэл гэдэг нь мэдээж хэрэг.

Там дахь мөнхийн зовлон шаналалал нь шийтгэл үү?

Христын сүм хийдийнхний үздэгээр бол бидний амьдрал оршихуй бид энэхүү амьдралаа хэрхэн амьдарч өнгөрүүлж байгаагаас л хамаардаг. Бүх нийтээр заншсан ёс журмыг сахиж биелүүлэхгүй байх аваас бид тамын хамгийн харанхуй хэсэгт ямар ч аврагдалгүйгээр эрсдэн унах болно гэж үздэг. Дахин төрөхүйн хуулиудын талаарх мэдлэг нь хүмүүсийн иймэрхүү буруу төсөөллүүдийг арилгадаг. Бурханыг бодитойгоор ухааран байгаа хүмүүс бүрнээ ойлгомжтой учир шалтгаанаар дээд шудрага үнэний ийм системийг бурханлаг гэхээсээ демонлог гэж үздэг. Хүн л зөөлөн сэтгэл гаргадаг, бусдыг энэрч нигүүлсдэг, харин Бурхан бол тийм биш гэсэн явдал байж болно гэж үү? Иймэрхүү үндэслэл баримтгүй номлолууд нь Бурхан болон Түүний бодьгал дэлгэрэлүүд болох амьд оршнол хоёрын хоорондын хайрын мөнхийн холбоог үл хайхарч эс ойшоодог. Хүн бол Бурхантай төстэй, Түүний хэлбэр дүртэйгээр бүтээгдсэн учраас Бурхан бүхий л шинж чанаруудыг

хамгийн төгс төгөлдөр байдлаар агуулдаг байх ёстой. Эдгээр шинж чанаруудын нэг нь— энэрэн нигүүлсэхүй. Хүн ганцхан богинохон амьдралын дараагаар тамын мөнхийн зовлон шаналал руу илгээгддэг байж болох гэдэгт итгэх явдал нь хэмжээ хязгааргүй өршөөнгүй, энэрэнгүй Бурханы таалал буюу үзэл баримтлалтай таарц нийцэхгүй. Тэр бүү хэл, зүгээр нэг эгэл жирийн эцэг хүн хүртэл хүүгээ сайн сайхан амьдралд хүргэхийн тулд түүнд нэгээс илүү олон боломжийг өгдөг, олгодог.

Ведийн бичээсүүд Бурханы уудам санаа, өршөөнгүй ариун сэтгэлт шинж чанаруудыг цуцалтгүйгээр магтан дуулдаг, алдаршуулдаг. Кришна, тэр бүү хэл Өөрт нь илтээр дайсагнаж үзэн ядагсадад хүртэл өршөөнгүйгээр, энэрэнгүйгээр ханддаг. Тэрээр амьд оршнол бүрийн зүрхэнд залран байдаг бөгөөд мөрөөдөл болон их зангаа хэрэгжүүлэх боломжийг түүнд өгдөг. Чухамдаа бол Бурханы өршөөл энэрэл, хайранд хязгаар байдаггүй. Кришна бол хэмжээлшгүй өршөөнгүй, энэрэнгүй. Бид энэхүү өршөөл, хайрыг нүгэлт үйлүүдээсээ болоод хүртэж чадахгүй байгаа боловч Бурхан үхэл төрөлт дахин давтагдах хүрдний хүрээ хязгаарын чанадад гарах боломжийг амьд оршнолд үргэлжид хэвээр үлдээдэг.

Дахин төрөхүйн онолоор бол Бурханы Дээд Бодьгал Кришна, Өөрт нь зориулан хийсэн их биш ч гэсэн сайн зүйлүүдийг бүгдийг нь, тэр бүү хэл хамгийн муу хүн байсан ч, анхааралдаа авч, санадаг. 100% нүгэлтэй хүн гэж ховор билээ. Иймээс амьд оршнол энэ амьдралдаа бурханлаг хөгжил дэвшилд хүрэхээр бага зэрэг ч гэсэн оролдлого хийх аваас дараагийн амьдралдаа тэрхүү хүрсэн түвшингээсээ эхлүүлэн цаашид үргэлжлүүлэх болно. Сүнс өөрт байдаг бурханлаг шинж чанаруудаа ийм байдлаар олон амьдралын туршид хөгжүүлж болдог бөгөөд ингэснийхээ үрээр Бурханы зүгт гэрлүүгээ буцаад харихыг зөвшөөрдөг түвшинд хүрдэг.

Материаллаг амьдрал оршихуйн хүндрэл бэрхшээлтэй асуудлууд.

Хүн үйлээ Бурханы хуулиудыг гажиж зөрчилгүйгээр хийж үйлдэн сайн карма хурааж хуримтлуулсан байлаа ч гэсэн буянт сайн үйлүүдийнхээ үр дагаврыг амсаж эдлэхээр тэртэй тэргүй дахин төрөх болдог. Таашаал ханамжийг саад тотгоргүйгээр амсаж эдэлж болдог диваажингийн гаригууд дээр дээшлэн очсон байлаа ч тэндээ үүрд үлдэж байж чадахгүй. Эрт орой хэзээ нэгэн цагт энэхүү таашаал ханамжинд төгсгөл ирдэг. Бид шинэ бие махбодь авч байгаа л бол энэ нь бид төрөлт, хөгшрөлт, өвчлөл болон үхлийн зовлон шаналалыг туулах ёстой болж байна гэсэн үг. Үүнд аймшигтай зүйл огтхон ч байхгүй юм шиг санагдаж байж болох ч материаллаг ертөнцөд төрнө гэдэг бол сүнсний хувьд салхинд гарч зугаалж яваа явдал огт биш. Хүний үр хөврөл 9 сарын туршид эхийн ходоодонд асаж байгаа хоол боловсруулах галд халж шарагдаж байгаа зай муутай бариу давчуу хийгээд харанхуй саван дотор байрладаг. Эх нь хөдлөх үедээ түүнийг доргиож сэгсчих бөгөөд савны хана болон ойр хавьцаа байрлах эрхтэнгүүдийн зүгээс түүнд байнга даралт шахалт учруулна. Тэрээр цаг үргэлжид нуруугаа нум мэт бөгтийлгөсөн нэгэн хэвийн байрлалтай, байдалтай байна. Ирээдүйн бяцхан амьтан тэрээр хэвлийн хөндий дотор оршин байгаа өлсгөлөн өт хорхойнуудад хазуулан шаналахын зэрэгцээ өлсөж ундаассанаасаа болоод зовно. Ведэд өгүүлсний дагуу бол төрж байгаа хүн ой санамжиндаа хадгалагдаж байгаа өнгөрсөн амьдралуудынхаа талаарх санамж дурсамжуудыг бүгдийг мартахаар тэгж их зовж тарчлан гардаг байна.

Аугаа мэргэн Капила Муни үхэх үйл явцын жинхэнэ мөн чанарын талаар ээждээ: “Энэхүү зовлон шаналалт төлөв байдалд нүд дотроос үзүүлэх хийн даралтаас болж бүлтийдэг, харин хоолой салстаар дүүрэн таглардаг. Ийм зүйл болж учирч байгаа хүний амьсгал нь давчдан хоолой нь хяхтнан дуугардаг. Тэрээр өвдөж байгаагаасаа болоод зовж шаналах хийгээд ухамсраа алдан үхдэг.” (Ш.Б. 3.30.16-18) гэж өгүүдэг.

Сүнс бие махбодь дахь амьдралдаа, байгалийн хуулиуд түүнийг тэндээс үхлийн мөчид албадан гаргах хүртэл тэгж дассан байдаг. Амьдарч байгаа орон байрнаас нь хүчээр гаргах явдал хэнд ч таалагддаггүй шигээр материаллаг бие махбодиос нь албадан гаргахад сүнс эсэргүүцэл үзүүлэх нь зүй ёсны хэрэг. Тэр бүү хэл, хамгийн өчүүхэн жижиг мөлхөгчид хүртэл амьдралд нь аюул занал учрах үед үхлээс зайлсхийхийн тулд ер бусын чадвар болон арга мэх гаргадаг. Гэхдээ л бүх амьд оршнолуудын хувьд үхэл бол зайлшгүй зүйл. Мөн тэрчлэн үхлийг дагалдан байдаг айдас хүйдэс болон өвдөлт зовиур ч гэсэн мөн адил.

Өөрийгөө уяж хүлэлгүйгээр үйл хөдлөлөө яаж хийж үйлдэх вэ?

Тэгэхлээр хүн нүгэлт муу үйл үйлдэх ёсгүй байна. Гэхдээ үүний зэрэгцээ буянтай буюу сайн

үр дагавар дагуулах үйл ажиллагаа ч гэсэн мөн л учир утгагүй зүйл. Тэгвэл хүн ажил үйлээ яаж үйлдэх хэрэгтэй гэж? Үйл ажиллагаагаа трансценденталь суурин дээр үндэслэн явуулах хэрэгтэй. Энэ нь өөрийн бүхий л үйлээ Кришнаатай холбох хэрэгтэй гэсэн үг юм. Ийм үйл ажиллагааг акарма гэж нэрлэдэг. Ийн үйлдэж байгаа хүнд материаллаг мөн чанарын гурван гунууд нөлөөлдөггүй бөгөөд тэрээр төрөлт үхлийн эргэлдэх хүрднээс ангижран гарч Бурханы оронд буцан очдог. Жишээ нь, нэг ангийн хоёр оюутны нэг нь Бурханы чин бишрэлтэн, нөгөө нь үр дүнгийн төлөөнөө зүтгэж байгаа материалист байг. Чин бишрэлтэн оюутан Кришнагийн төлөө, Түүнд зориулан суралцдаг. Яаж? Тэр чинь материаллаг мэдлэг л авч эзэмшиж байгаа биз дээ? гэж та асууж байж болох. Чин бишрэлтэн оюутан суралцаж байгаагийнхаа зорилгыг ойлгож байдаг. Энэ зорилго нь түүнийг ирээдүйд гэр бүл болон ойр дотныхноо тэжээн тэтгэх ажилтай болгоход оршдог. Гэхдээ тэр хэн бүхний хувьд жинхэнэ, мөнхийн амьдрал болон мөнхийн харилцаанууд нь зөвхөн Кришнаатай холбогдсон байдаг гэдгийг мэддэг. Тиймээс тэр өдөр бүр тогтсон тоотой тойрог маха-мантра-гаа эрхин дээрээ уншдаг, зохицуулах дөрвөн зарчмаа баримталдаг, хөтөлбөрөө үзэж судалдаг бөгөөд ухамсраа цэвэр ариун байдалд ийн байлгадаг. Түүнээс гадна, тэрээр энэхүү үйл ажиллагааг өөрт оноогдсон үүрэг байдлаар хүлээж аван сургуульдаа үргэлжлүүлэн суралцдаг.

Эхлээд харахад, хоёр оюутан хоёулаа нэг адил үйл үйлдэж байгаа юм шиг санагдаж байвч үнэн хэрэгтээ тэдний хооронд маш том ялгаа байна. Өөрийн хөдөлмөрийн үр дүнгээр таашаал ханамж эдлэхийн төлөө ажиллаж зүтгэж байгаа оюутан ирээдүйнхээ талаар асар том төлөвлөгөө зохион байдаг ба ингэснийхээ үр дүнд нь материаллаг мөн чанарын гунуудад улам бүр ихээр орооцолддог. Тэгвэл үйл хэргээ Кришнагийн ухамсарт үйлдэж байгаа чин бишрэлтэн-оюутан гунуудын нөлөөнөөс алхам алхамаар салан ангижирч цэвэр-цэвэр ариун (трансценденталь түвшин)-д хүрдэг. Гунууд түүнд үйлчлэл нөлөөллөө үзүүлэхээ хэдийнээ больсон байх бөгөөд ийм чин бишрэлтэн дээр Кришнагийн хайр нигүүлсэл тасралтгүйгээр асгаран цутгадаг.

Йога гэж юу вэ?

Бурхан Кришнагийн Бхагавад Гита-д айлдсан айлдвар сургаалын учир утга нь хүн бол йогч буюу амьдралаа йогын замаар замнахад зориулж байгаа тийм хүн болох ёстой гэдэгт оршдог. Гэхдээ йога гэж юу вэ? Йога гэдэг санскрит үг нь "холбоо" гэсэн утгатай бөгөөд бие даасан ухамсрын Дээд ухамсартай, сүнсний Дээд Сүнтэй, өөрөөр хэлбэл Бурхантай холбогдсон хайрын холбоонд хамааралтай.

Бхагавад Гита-гаас бид йогын үндсэн дөрвөн хэлбэрийн тодорхойлолтыг олж үзэж болно. Карма-йогын замаар замнаж байгаа хүн ажил хөдөлмөрөө үр дүнг нь өөрөө хүртэх гэсэн аминч хүсэлгүйгээр Бурханд зориулан хийж үйлддэг. Гьяна-йога бол мэдлэгээ хөгжүүлэх замаар ухамсраа бурханлаг түвшинд дээшлүүлэн хүргэх үйл явц юм. Аштанга-йога буюу дхьяна-йога бол ухаанаа хянан захирах болон түүнийг Бүхний Дээдэд төвлөрүүлэхэд хүргэдэг механик бясалгалын үйл. Хатха-йога бол аштанга-йогын хялбаршуулсан буюу энгийн болгосон систем. Йогын энэ бүх системүүд нь Кришнад хайр харамгүйгээр хариу нэхэлгүйгээр, цаанаасаа өөрөө аяндаа оргилон ундрах чин бишрэлтэйгээр үйлчлэн зүтгэх бхатки-йога-д хүрснээр дээд цэгтээ, оргилдоо хүрдэг. Кришна Өөрөө үүнийг батлан ийн айлддаг: "Бүх йогчдоос хэлбэрэдт гуйвалтгүй итгэл бишрэл дүүрэн байж, үргэлж Надад оршиж, Миний тухай бодолд байнгад автан умбаж, Надад трансценденталь хайр дүүрэн зүтгэж, Надтай хамгийн дотно бат бэх холбогдсон тэр л хамгийн дээд нь байдаг. Миний таалал бодол ийм болой." (Б.-г., 6.47).

Үйл ажиллагаа нь Бурхантай холбогдсон холбоо харьцаагаа сэргээхэд чиглэгдэхгүй байгаа хүнийг йогч гэж нэрлэх аргагүй.

Карма-йога

Үр дүнгийн төлөө энэ ертөнцөд үйлдэж байгаа үйл ажиллагаа нь дараах үр дагавруудыг араасаа дагуулдаг буюу авчирдаг. Ажил хөдөлмөрийнхөө үр дүнг таашаан ханамж эдэлж байгаа хүн энэхүү үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн байх урам зоригтой болдог бөгөөд үүнийхээ үр дүнд дахиад өөр үр дагаврыг, гэхдээ энэ үр дагаврынхаа хамтаар шинэ карма-г авдаг. Үйлийн энэхүү үйл явц болон түүний араасаа дагуулж байгаа үр дагавар нь хязгааргүй буюу эцэс төгсгөлгүй олон салаа мөчрийг багсайтал ургуулж байгаа мод ургамалтай төстэй юм. Ийм үйл ажиллагаа эрхэлж байгаа буюу хийж үйлдэж байгаа хүн ганц амьдралын хугацааны дотор ч гэсэн кармын эргэлдэх хүрдэнд

татагдан орж, бүрэн автдаг. Ингэсний улмаас буюу хор уршгаар сүнс 8 сая 400 мянган амьдралын хэлбэрийг туулах хийгээд гурвалсан зовлон шаналалд (өөрийн бие махбодь болон ухааны зүгээс учруулах зовлон шаналал; бусад амьд оршнолуудын зүгээс учруулах зовлон шаналал; материаллаг мөн чанар буюу байгалийн зүгээс учруулах зовлон бэрхшээл) нэрвэгдэх болдог. Гэхдээ хүмүүс ийм үйл ажиллагааны хэлбэрээс татгалзах нь боломжгүй гэж үздэг. Хүн буянтай сайн үйл үйлдсэн хийгээд диваажингийн гаригуудад дээшлэн хүрч очсон байлаа ч сайн карма нь барагдан дуусах цагт энэ дэлхий дээр дахин төрөх хийгээд төрөлт, хөгшрөлт, өвчлөл болон үхлээс болж зовж шаналахаас өөр аргагүй тийм байдалд ордог. Иймд, сайн эсвэл муу аль ч үйл байлаа гэсэн биднийг төрөлт үхлийн эргэлдэх хүрдэнд унагадаг.

Аливаа үйлээ орших буюу түүнээс татгалзах гэж оролдох нь асуудлын шийдвэр болохгүй. Арджуна дайчин эрийн үүргээсээ татгалзах гэхэд Кришна ийн зөвлөдөг: “Өөрт оноогдсон үүргээ биелүүл. Ингэх нь юу ч үл үйлдэхээс дээр. Юу ч хийхгүй байх аваас хүн материаллаг бие махбодио ч тэжээн тэтгэж чадахгүй болно шүү дээ.” (Б.-г., 3.8).

Өөрт оноогдсон үүргээ биелүүлэхийг үл хайхран эс ойшоох нь эмх замбараагүй байдалд хүргэдэг учраас энэ талын бурханлаг эх сурвалжийн зөвшөөрөлгүйгээр ийн үйлдэж болохгүй. Ямар нэгэн ажил үйл хийж үйлдэхгүй байх аваас бие махбодио ч тэжээн тэтгэх нь боломжгүй болох учраас бид үйл ажиллагаанаасаа бүрмөсөн татгалзах ёсгүй. Тэр бүү хэл нүгэл үйлдэхгүйн тулд бүх талаар болгоомжилж сэрэмжилж байлаа ч агаар амьсгалах эсвэл зүгээр явж байх үедээ маш олон тооны өчүүхэн жижиг шавьж хорхойнуудыг өөрөө ч анзаарч мэдэлгүйгээр хөнөөж байж болох. Смрити зэрэг хуулиудын номуудад өгүүлсэнчлэн, хүн өөрөө хүсээгүй ч дараахь 5 төрлийн нүгэлт үйлүүдийг үйлдэж байдаг:

1. Маажих явцдаа үйлдэж байгаа нүгэлт үйл.
2. Илж, үрэх явцдаа үйлдэж байгаа нүгэлт үйл.
3. Гал асааж ноцоох үедээ үйлдэж байгаа нүгэлт үйл.
4. Хувин савнаас ус асгах явцдаа үйлдэж байгаа нүгэлт үйл.
5. Орон гэрээ янзалж цэвэрлэх явцдаа үйлдэж байгаа нүгэлт үйл.

Бид санаатайгаар нүгэл үйлдээгүй байлаа ч дээр дурьдсан 5 төрлийн нүгэлт үйлүүдийг тэртэй тэргүй л үйлдэх болно. Үр дагавар авчрах буюу дагуулах үйл ажиллагааны хөрс суурин дээр багсайтал ургах материаллаг орооцолдоон ширэлдээний мод тайван амгалан амьдарч орших найдварыг авчирч чадахгүй.

Үр дагавраас зайлсхийхийн тулд үйлээ яаж үйлдэх вэ? Бурхан Кришна энэ асуултанд ийн хариу айлддаг: “Хүн өөрийн үйлээ Вишнуд өргөл болгон зориулах хэрэгтэй. Эс тэгэх аваас тэр ажил үйл нь түүнийг материаллаг ертөнцөд уяж хүлэх болно. Ай Кунтийн хүү минь ээ, иймд өөрт оноогдсон үүргээ Түүнийг цэнгүүлэхийн төлөө биелүүл. Ингэж байж л чи материаллаг боолчлолын уяа хүлээснээс үргэлж ангид байх болно.” (Б.-г., 3.9).

Вишнуг цэнгүүлэхийн төлөө зориулан үйлдэж байгаа үйл ажиллагаа бол карма-гаас жинхэнэ ёсоор ангид, эрх чөлөөтэй байгаа хэрэг бөгөөд карма-йогын дээдийн дээд урлаг юм. Кришнад өргөсөн зоог нь бидний хүсэл зорилгын гадуур үйлдэгдсэн нүгэлт үйлүүдийн үр дагавраас зайлах боломжийг олгодог учраас зөвхөн тийм идээ зоогийг л хүртэж байх нь чухал. Санатана-дхарма-г баримталж байгаа гэр бүлийн амьдралын хэвшилд амьдардаг хүмүүс чухамхүү энэ учир шалтгаанаар гэр орондоо Вишну Бурханыг залан бишрэл хүндэтгэлээ илэрхийлдэг. Хоолоо Вишнуд өргөлгүйгээр, зөвхөн өөрийн мэдрэхүйн эрхтэн хэлэндээ таашаал ханамж эдлүүлэхийн төлөө хийж бэлтгэж байгаа хүн өөрт оноогдсон үүргээ биелүүлэх явцдаа санамсаргүйгээр үйлдсэн бүхий л нүгэлт үйлийнхээ үр дагавраас болж зовж шаналах болно.

Гьяна-йога.

Трансцендентальчдыг имперсоналистууд болон персоналистууд буюу бодьгал бусыг баримтлагчид болон бодьгалыг баримтлагчид гэсэн хоёр ангид хувааж болно. Чин бишрэлтэн-персоналист нь Бүхний Дээд Бурханд үйлчлэн зүтгэхэд өөрийгөө бүрнээ зориулдаг. Тэгвэл имперсоналист бол Кришнад үйлчлэн зүтгэхэд өөрийгөө зориулдаггүй, харин үл илэрч тодордог бодьгал бус Брахманыг бясалгадаг. Бурханы ойлгож ухаарахын аргагүй хийгээд үл илэрч тодордог, бодьгал бус төлвийг бясалгах замыг даган замнаж байгаа трансцендентальчдыг гьяна-йогчид, харин Кришнагийн ухамсарт бүрнээ оршин байж, Бурханы чин бишрэлийн албанд зүтгэдэг

трансцендентальчдыг бхакти-йогчид гэж нэрлэдэг.

Гьяна-йогын үйл нь эцсийн эцэстээ мөн л Бурханд хүргэдэг хэдий ч болзолдож нөхцөлдсөн сүнсний хувьд илүү жам ёсны хийгээд илүү энгийн хялбар байдаг Бурханы Дээд Бодьгалд шууд үйлчлэн зүтгэх алба— бхакти-йогын зам мөрөөс хавьгүй их төвөгтэй.

Бүхний Дээд Бурхан тийш хандаж чиглэсэн зам мөр дээрээ чин бишрэлтэнгүүд онцгой саад бэрхтэй учирдаггүй, тийм зүйл туулдаггүй, тэд зорилгодоо хурдан түргэн хүрдэг. Харин бодьгал бусын зам мөрөөр замнагсад олон хүндрэл бэрхшээлүүдтэй учирч тулгардаг. Тэд Упанишадууд зэрэг ведийн бичээсүүдээр дамжуулан Бурханы үл илэрч тодорсон төлвийг ухаарахыг оролддог. Ингэхийн тулд тэд эхлээд хэлийг нь сурах хэрэгтэй болдог. Дараа нь “Энэ бол биш, бас тэр бол биш.” гэсэн маягаар сүнс болон материйн хоорондын ялгааг ухаарахыг оролддог. Үнэндээ бол тэд ухаан бодлын түвшинд цэцэрхцгээх бөгөөд үүнийхээ тусламжтайгаар сүнсний мөн чанарыг ойлгох гэж оролдоцгооно.

Кришнагийн чин бишрэлтэн зүгээр л Шүтээндээ бишрэл хүндэтгэлээ илэрхийлж мөргөн, Бурханы алдар сууны талаар сонсон, мөн Бурханд өргөсөн зоогноос хүртэн бурханлаг номын багшийнхаа удирдлага дор алба зүтгэлдээ зүтгэдэг. Ийнхүү бүхий л мэдрэхүйнүүдээ үйлчлэн зүтгэх үйлд хамруулан оролцуулж байгаа тэрээр Бурханы Дээд Бодьгалыг ямар ч хүндрэлгүйгээр ухаардаг. Имперсоналистууд амьдралынхаа эцэс хүртлээ зорьсон зорилгодоо хүрч чадах эсэхээ эрсдүүлэн байж маш хүнд бэрх замыг үндэслэлгүйгээр сонгодог гэдэг нь эргэлзээгүй хэрэг. Тэгвэл юуг ч үл эрсдүүлдэг хийгээд ямар ч илүүц хүндрэл бэрхшээлийг буй болгохгүй байгаа чин бишрэлтэн Бурханы Дээд Бодьгалд шууд ойртон дөхдөг.

Бхагавад Гита-гийн 12 дугаар бүлэгт Кришна, Арджуна хоёрын хооронд өрнөх ярианаас бхакти-йога бол гьяна-йогаас илүү дээр гэдэг нь тов тодорхой болдог.

Арджуна: “Таны чин бишрэл дүүрэн бялхах албанд байнгад зөвөөр зүтгэгч эсвэл үл илэрч тодрох бодьгал бус Брахманыг шүтэн бишрэгчийн хэнийг нь илүү төгс төгөлдөр гэж үзэх вэ?” (Б.-г., 12.1) гэж асуухад

Кришна ийн хариу айлддаг: “Миний бодьгал дүрд ухаанаа төвлөрүүлэн, Надад трансценденталь гүн итгэл бишрэлтэйгээр хүндэтгэлээ үргэлжид илэрхийлэх хэн бүхнийг төгс төгөлдөрийн дээдийн дээд түвшинд хүрсэн хэмээн Би үздэг.” (Б.-г., 12.2).

Мөн дараагийн шүлгүүдэд Кришна ийн батлан айлддаг: “Бүхний Дээдийн үл илрэн тодрох, бодьгал бус төлөвт ухаан нь автан байх хэн бүхний хувьд бурханлаг хөгжлийн замаар урагшлах маш хүнд бэрх байдаг. Энэ зам мөрөөр замнан урагшилж ахиц дэвшилд хүрнэ гэдэг бие махбодид төрсөн сүнсний хувьд ямагт маш хүнд бэрх байдаг.” (Б.-г., 12.5).

Дхьяна-йога буюу аштанга-йога.

Аштанга-йога бол яма, нияма, асана, пранаяма, пратьяхара, дхарана, дхьяна болон самадхи гэсэн найман шатлалт үйл явц юм. Пратьяхарагийн шатанд аштанга-йогч мэдрэхүйгээ дуу авиа, хүртэхүй, дүрс хэлбэр, амт болон үнэр гэсэн мэдрэхүйн объектуудаас салган холдуулж, дараа нь нүдээ хагас анин харцаа хамрынхаа үзүүрт төвлөрүүлэн байх ёстой. Нүдээ бүрэн аньж болохгүй, тэгэх аваас унтчихна. Мөн нүдээ нээлттэй байлгах хэрэггүй, учир нь тэгж байгаа тохиолдолд мэдрэхүйн объектой харилцан холбогдох аюул учирна. Йогч бие махбодь доторх дээш өгсөх болон доош буух хийн урсгалаа саармагжуулангаа амьсгалах үйл явцаа зогсоодог. Ийнхүү үйлдэн байгаа хүн мэдрэхүйгээ залан захирч, гадны объектуудаас огоордог бөгөөд ангижралд ийм байдлаар бэлтгэдэг. Аштанга-йога бол дхьяна-йогын эхлэл.

Найман шатлалт йогын үйлийг дөнгөж эхлэн байгаа хүний хувьд бясалгахад нь тус нэмэр болдог бие махбодийн дасгалуудыг материаллаг үйл ажиллагаа гэж тооцдог. Энэ түвшиндээ батжин бэхжсэнээр тэрээр зорилгодоо хүрэхэд нь тус болдог арга хэрэгсэл л төдий байдаг иймэрхүү механик үйл ажиллагаагаа зогсоон больдог. Йогын дээд түвшинд хүрсэн цагтаа хүн бүхий л материаллаг хүслээсээ татгалзан Бурханы трансценденталь хайр дүүрэн бялхах албанд зүтгэж эхэлдэг. Тэрээр мэдрэхүйдээ таашаал ханамж эдлүүлэхийн төлөөх үйлэнд зүтгэхээ больдог хийгээд ажил хөдөлмөрийнхөө үр дүнг таашаан ханамж эдэлдэггүй.

Аштанга-йогыг хэрэгжүүлж байгаагийн үр дүнд хүн анима (жигжээс жижиг болдог), махима (томоос том болдог), лагхима (хөнгөнөөс хөнгөн болдог), мөн тэрчлэн прапти, ишита, пракамья, вашита болон камавасаита гэсэн ид шидийн найман төгс төгөлдөр байдалд хүрч болдог. Энэ бүх

төгс төгөлдөр байдлууд нь ид шидэт йогын дээд түвшинд хүрэх үед бий болдог буюу илрэн гардаг дагалдах үзэгдлүүд. Дээд дурьдсан төгс төгөлдөр байдлуудаас нэг эсвэл хоёрт нь хүрснээр олон ид шидтэнгүүд ухааны хэлбэлзэл буюу тээнэгэлзлэлийн урхинд ордог бөгөөд ингэсний хор уршгаар Бурханыг цэвэр чин бишрэх— дээдийн дээд төгс төгөлдөрт хүрч чаддаггүй.

Харин Кришнагийн чин бишрэлтэнгийн анхаарал Бурханы трансценденталь албанд бүрнээ төвлөрсөн байдаг болохоор унахаас айдаггүй. Төвлөрөхийн тулд транст орохын хэрэг түүнд байдаггүй. Чин бишрэлтэн ид шидийн төгс төгөлдөр байдалд татагддаггүй. Үйлчлэл зүтгэлийн нь объект буюу Шүтээн Шри Кришнад дурлан татагдах татагдал нь байнгад өсөн нэмэгдэж байдаг болохоор тэдгээр ид шидийн төгс төгөлдөр байдлууд нь түүнд үл ялих, шалихгүй зүйл мэт санагддаг. Бурханд үйлчлэн зүтгэх албанд тийм их аз жаргал байдаг гэдгийг материалист хүмүүс ойлгодоггүй гэдэг нь лавтай хэрэг.

Аштанга-йога нь ийм дүрэм журамтай: Эхний алхам нь аглаг зэлүүд газар орон олоход оршдог. Найман шатлалт йогыг том хотод хэрэгжүүлэх аргагүй. Целибат (гэр бүл болохгүйн зарчим)-ыг баримталж, сексээс бүрнээ таггалзах ёстой. Хэт их идэх болон унтах хориотой. Ийнхүү хоол, нойр, ажил амралтын дэглэмээ зохицуулан байгаа йогч ухаанаа номхруулан дардаг бөгөөд материаллаг хүслүүдээ бүрмөсөн таягдан хаяснаар түүнийг Парамтамад төвлөрүүлдэг. Ийм йогчийн ухаан бол салхигүй орчинд асаж байгаа зулын галын дөлтэй адил юм: тэрээр байнгад Бурханд төвлөрөн байдаг.

Транс буюу самадхи гэж нэрлэгддэг төгс төгөлдөр төлөв байдалд байгаа хүний ухаан материаллаг үйл ажиллагаанаас бүрнээ тасран салдаг. Ухаан нь Кришнад төвлөрсөн байдаг йогч дээдийн дээд төгс төгөлдөр байдалд хүрдэг бөгөөд трансценденталь аз жаргалд умбадаг. Бүхний Дээдтэй байнгын холбоонд байгаа, өөрийгөө ийн эзэмдэн захирч хянадаг йогч материаллаг бузраас ангижирдаг бөгөөд Кришнад хайр дүүрэн үйлчлэн зүтгэх алба үйлэн дэх төгс төгөлдөр байдлын дээдийн дээд шатанд хүрдэг.

Манай энэ цаг үе Кали юга-д аштанга-йогыг хэрэгжүүлэх явдал нь хязгаарлагдмал. Зөвхөн өнөөдөр ч биш, мөн дэлхий дээрх нөхцөл байдал огтын өөр байсан 5000 гаруй жилийн өмнө ч гэсэн аштанга-йогыг хэрэгжүүлэх нь бараг боломжгүй байсан. Тэр бүү хэл Бурхан Кришнаатай хамт амьдарч байсан, Түүний ойр дотнын найз аугаа дайчин, хан хүү Арджуна шиг тийм аугаа бодьгал хүртэл йогын энэхүү үйлийн талаар сонсоод ийн хэлсэн байдаг: “Ай Мадхусудана минь ээ, ухаан тайван бус, мөн тууштай бус байдаг учраас Таны надад товчхон айлдаж байгаа йогын энэ систем миний хувьд хэрэгжүүлэх аргагүй юм. Ухаан бол тайван бус, догшин, зөрүүд бөгөөд маш хүчирхэг. Ай Кришна минь ээ, түүнийг эзэмдэн захирна гэдэг миний бодлоор бол салхийг хянан захирахаас ч хүнд бэрх, ярвигтай.” (Б.-г., 6.33-34). Энэхүү цаг үе Кали юга-д эгэл жирийн хүн аштанга-йогыг хэрэгжүүлэхээр гэр орноо орхин аглаг зэлүүд газарт, уул нуруу эсвэл ой шугуйд очиж чадахгүй. Одоогийн энэ цаг үе нь амьдралын төлөөний хатуу ширүүн тэмцлээрээ ялгардаг. Хүмүүс өөрийгөө төгөлдөржүүлэх тал дээр нухацтай ханддаггүй; тэд амьдралын төлөв маягаа хянан захирах, суудлын янз бүрийн байрлалын дасгал сургуулилт хийх, очин сурьших газар орчноо нарийн чанд сонгох болон материаллаг үйл ажиллагаанаас ухаанаа татгалзуулан холдуулах зэргийг өөртөө багтаадаг йогын энэхүү төвөгтэй системийг бүү хэл энгийн бөгөөд амьдралд бодитойгоор хэрэгжүүлэх боломжтой арга хэрэгслийг ашиглан төгс төгөлдөрт хүрэхийг ч хүсдэггүй. Арджуна хөгжил дэвшлийн онцгой өндөрлөгт хүрсэн бодьгал байсан ч гэсэн асуудлыг бодитойгоор ойлгодог хүн мөн болохын хувьд йогын энэхүү системийг даган баримтлах буюу хэрэгжүүлэх нь зүгээр л боломжгүй юм байна гэж үзсэн. Иймээс энэхүү цаг үе Кали юга-д аштанга-йогыг хэрэгжүүлэх нь боломжгүй гэж үздэг. Мэдээж, зарим аугаа сүнснүүд түүнийг хэрэгжүүлж чадаж байж болох ч нийгмээрээ, нийтээрээ бол хүлээж авах аргагүй юм. 5000 жилийн өмнө тэртээ ийм байсан бол одоо эдүгээгийн цагийн тухайд юу ярих билээ? Йогын энэхүү системийг йогын “сургууль” болон “нийгэмлэг” гэж нэрлэгддэг байгууллагуудад хийхийг дуурайн байгаа хүмүүс хэдийгээр үүгээрээ бардамнан байж болох ч үнэн хэрэгтээ бол цаг хугацаагаа хий дэмий хоосон үрэн таран хийж байгаа хэрэг. Тэд өөрийн хийж үйлдэж байна гэх үйлийн эцсийн зорилготой харьцуулахад бүрнээ харанхуй мунхаг байдалд оршин байдаг. Бхакти-йогын зарчмуудыг хэрэгжүүлэх буюу даган баримтлах нь дхьяна-йогыг энэ цаг үед хэрэгжүүлэх гэхээс илүү.

Бхакти-йога бол йогын дээд систем.

Бхакти-йога бол амьд оршнолын Кришнаатай холбогдсон холбоо хийгээд Түүнтэй холбогдсон түүний мөнхийн харьцаануудын сэргэлт юм. Бурханы аугааг хүлээн зөвшөөрөх нь бхактийн эхлэл. Бхакти-йога өөртөө гурван талыг агуулдаг: Үйлчлэл зүтгэлийг хүлээн авагч буюу Болгоон таалагч, албат үйлчлэгч буюу үйлчлэн зүтгэгч болон үйлчлэл зүтгэл өөрөө. Үйлчлэн зүтгэхийн тулд бодьгал байх ёстой, үйлчлэл зүтгэлийг хүлээн авагч буюу Болгоон таалагч нь мөн л Бодьгал байх ёстой. Тэдний хооронд үйлчлэл зүтгэл өөрөө буюу бхакти-йога байдаг. Амьд оршнолууд бол Кришнагийн мөнхийн албатууд. Анхдагч жинхэнэ байр сууриндаа бол тэд Бурханы албатын албат байхыг мөрөөддөг. Бүхнийг татагч, дээдийн дээд Таашаан цэнгэгч, Бурхан Шри Кришна бол үйлчлэл зүтгэлийг Болгоон Таашаагч. Чин бишрэлийн алба зүтгэлийн 9 стандарт хэлбэрүүд байдаг бөгөөд тэдгээрийн алиныг нь ч гэсэн сонгож болно. Бурханд өргөл болгон өргөж буй үйлчлэл зүтгэлийн аль ч хэлбэр нь байсан гэсэн үнэмлэхүй, тэдний хооронд тооны болон чанарын ямар ч ялгаа байхгүй. Бурханлаг түвшинд трансценденталь олон талт байдал буюу олон янз байдал оршдог. Бхактийн хэлбэрүүдээс нэгийг нь эсвэл нэгэн зэрэг хэд хэдийг нь хэрэгжүүлснээр буюу даган баримталснаар олон бодьгалууд бурханлаг амьдралын төгс төгөлдөрт хүрсэн. Тэдгээр бодьгалуудын заримыг дор дурьдваас:

1. СОНСОХ. Махараджа Парикшит Кришнагийн алдар цууны талаар аугаа бодьгал Шри Шукадева Госвамигаас зүгээр л сонссоноор чин бишрэлийн алба зүтгэлийн төгс төгөлдөрт хүрсэн.
2. МАГТАН АЛДАРШУУЛАХ. Шри Шукадева Госвами эцэг Шри Вьясадевагаас хүртсэн тэрхүү трансценденталь илгээлтийг давтан хэлснийхээ буюу өгүүлснийхээ ачаар өөрөө мөн тийм төгс төгөлдөрт хүрсэн.
3. БОДОЖ САНАХ. Прахлада Махараджа Бурхан Кришнагийн чин бишрэлтэн хийгээд аугаа ариун гэгээнтэн Шри Нарада Мунигаас хүртсэн сургаалаа дагаж биелүүлэн Бурханы тухай байнгад бодож санаж байсан болохоор бурханлаг төгс төгөлдөрт мөн л хүрсэн.
4. ҮЙЛЧЛЭН ЗҮТГЭХ. Цэцэглэн мандахын охин тэнгэр Лакшмиджи нь Бурханы бадамлянхуа өлмийд зүгээр л үйлчлэн зүтгэснийхээ ачаар амжилтанд хүрсэн.
5. БИШРЭЛ ХҮНДЭТГЭЛЭЭ ИЛЭРХИЙЛЖ МӨРГӨХ. Притху хаан Бурханд зүгээр л ийн мөргөснөөр амжилтанд хүрсэн.
6. ЗАЛБИРАХ. Улаач Акрура Бурханд залбирлаа өргөснөөр амжилтанд хүрсэн.
7. БУРХАНЫ АЙЛДВАР ТУШААЛЫГ БИЕЛҮҮЛЭХ. Рамачандра Бурханы чин бишрэлтэн Хануман Эзэнийхээ тушаалыг зүгээр л биелүүлснээр төгс төгөлдөрт хүрсэн.
8. БУРХАНТАЙ НАЙЗ НӨХРИЙН ХАРЬЦАА ТОГТООХ. Аугаа дайчин Арджуна түүнийг өөрийг нь болон түүний бүх дагалдагчид буюу түүний зам мөрийг даган баримтлагчдыг гэгээрүүлэхээр Бхагавад Гита-г айлдсан Бурхантай нөхөрлөж байсны ачаар төгс төгөлдөрт хүрсэн.
9. ӨӨРИЙГӨӨ БҮРНЭЭ ДААТГАХ. Бали Махараджа Бурханд өөрийн биеэ хүртэл өгч зориулсан буюу Түүнд өөрийгөө бүрнээ даатгаснаар амжилтанд хүрсэн.

Амбариша Махараджа чин бишрэлийн алба зүтгэлийн 9 хэлбэрийг бүгдийг нь хийж хэрэгжүүлснээр төгс төгөлдөр амжилтанд хүрсэн.

Туйлын сайн йогч бол бие нь аадар борооны үүл мэт өнгөтэй, бадамлянхуа царай нь нар лугаа туяаран байдаг, хувцас өмсгөл нь үнэт эрдэнийн чулуун шигтгээгээр гялалзах хийгээд хүзүүндээ анхилуун үнэртэй цэцэгсээр хийсэн хэлхээ зүүн чимэглэсэн Шьямасундара гэж нэрлэгддэг Кришнад анхаарлаа төвлөрүүлдэг. Түүнээс цацрах нүд гялбам туяа брахмаджьоти нь бүх орчлонгуудыг гийгүүлэн гэрэлтүүлдэг. Тэрээр Рама, Нрисимха, Враха болон Бурханы Дээд Бодьгал Кришна зэрэг янз бүрийн хувилгаан дүрүүдээр илрэн тодордог. Тэрээр Яшода ээжийн хүү болж хүний дүрээр морилон бууж ирдэг бөгөөд Түүнийг Кришна, Говинда болон Ваасудева гэж нэрлэдэг. Тэр бол туйлын сайн өв тэгш хүү, эр нөхөр, найз болон бурханлаг номын багш. Тэр бол бүхий л баялаг болон трансценденталь шинж чанаруудын биелэл. Бурханы эдгээр шинж чанаруудыг бүрэн төгс ухаарсан хүн бол дээдийн дээд йогч. Зөвхөн бхакти-йогын зам мөрөөр орж замнасаар л төгс төгөлдөрийн ийм түвшинд хүрч чадна. Иймээс бхакти бол йогын бүх үйл явцуудаас хамгийн төгс төгөлдөр нь. Йогын бусад бүх хэлбэрүүд нь бхактийн түвшинд аажмаар дээшлэн хүрэхэд зориулагдсан.

Кришнагийн ухамсарын үйлэнд зүтгэснээр юунд хүрдэг вэ?

Тэгэхлээр бид бол бие махбодь биш, харин сүнс. Бие махбодь бол түр зуурын, харин бие махбодь бүрт орших сүнс бол мөнх. Амьд оршнол бүр Бурханы Дээд Бодьгал Кришнаатай мөнхийн

хийгээд цэнгэл жаргал дүүрэн харилцаатай. Зөвхөн бурханлаг ертөнцөд, Бурхан Кришнагийн хажуу дэргэд л бид жинхэнэ, үнэ цэнэт амьдралаар амьдарч болно. Кришна үргэлжид бурханлаг ертөнцөд, Өөрт нь цэвэр чин бишрэлтэйгээр үйлчлэн зүтгэх тоо томшгүй олон хайрт бараа бологч-дагуулуудаараа хүрээлүүлэн заларч байдаг. Бурханлаг ертөнцийн оршин суугчид бол материаллаг хүсэл, шунал, тачаал, атаархалаас ангид чөлөөтэй, бүрнээ төгс төгөлдөр бодьгалууд.

Бурханлаг ертөнц дэх газар шороо, мод, байшин барилга болон ус гээд бүх зүйлс ухамсартай байдаг бөгөөд цэнгэл жаргалын биелэл. Тэнд уй гашуу, уйтгар гуниг гэж байдаггүй, харин зөвхөн аз жаргал, баяр хөөр л дүүрэн бялхаастай. Гэхдээ материаллаг ертөнцөд сүнсний амсаж эдэлдэг улиг болсон хийгээд ямар ч амтгүй таашаал ханамж биш. Тэнд сүнс Кришнаг хайрлах хайрын дээдийн дээд бурханлаг экстазыг амтлан эдэлж цэнгэн жаргадаг. Бурхан чин бишрэлтэнгүүдийнхээ хамтаар гайхамшигтай цэнгээн наадмуудаа өрнүүлэн байдаг. Тэнд дуу бүжиг, тоглоом наадам болон тансаг зоог идээ бүхий баяр цэнгээнүүд тасралтгүйгээр үргэлжлэн байх бөгөөд тэдгээрт Бурханы Дээд Бодьгал үргэлжид оролцдог.

Ухаангүй, бодлогогүйн улмаасаа Кришнад дайсагнасан байдал гаргах тийм сүнснүүд материаллаг ертөнц тийш илгээгддэг. Энэ ертөнц бол чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх газартай төстэй юм. Болзолдож нөхцөлдсөн сүнснүүд энд амьдралын 8 сая 400 мянган хэлбэрт хамаарагдах бие махбодийг аван төрөхөөс өөр гарцаагүй байдалд тулгагдан орж дахин давтагдах төрөлт болон үхлээс болж зовж шаналдаг. Хий хуурмаг байдалд бүрхэгдсэн хийгээд хуурмаг алдар хүндэд хордон мунхарсан тэд тэр бүү хэл ялгадас иддэг гахйаны бие махбодийг аван төрсөн байлаа ч аз жаргалтай байна хэмээн бодож явдаг. Энэхүү ертөнц нь хамгийн дээд гаригаасаа эхлүүлээд хамгийн доод гаригаа хүртэл бүхэлдээ зовлон шаналалын далай болохоос өөр юу ч биш билээ.

Материаллаг ертөнцөд биднийг ялзарч муудаж байхыг Кришна хүсдэггүй. Тэр биднийг Өөртэйгөө хамт мөнх хийгээд аз жаргал дүүрнээр амьдруулахын тулд гэртээ буцаж хариач, ирээч гэж уриалдаг, дууддаг. Оюунлаг хүн Кришнаг (Түүний Бхагавад Гита-д айлдсан айлдвар номлолыг) анхааран сонсдог бөгөөд тэгснээрээ дахин давтагдах төрөлт болон үхлийн асуудлыг шийдвэрлэхийг чармайдаг. Ийм хүн өөрийн Кришнагийн ухамсарыг сэрээх болон Бурханы зүгт буцан очихын тулд чин бишрэлийн албанд зүтгэдэг.

Бурханлаг оюун нь сэргэсэн байгаа хүмүүс одоогийн энэ амьдралаараа материаллаг ертөнц дэх оршихуйгаа дуусгавар болгохыг найдан Кришнагийн ухамсарыг үнэн сэтгэл, чин зүрхнээсээ хүлээн авдаг. Чин бишрэлийн албанд зүтгэснээрээ чин бишрэлтэнгүүд өөртөө бүхий л гайхамшигтай сайхан шинж чанаруудыг хөгжүүлдэг. Тэд сайхан сэтгэлтэй, тэвчээртэй, даруу, хүлцэнгүй, эв эетэй хийгээд сайн сайхныг хүсэгч болдог. Кришнагийн ухамсар эдийн засгийн, нийгмийн, улс төрийн, сэтгэл зүйн, философийн болон шашны бүхий л асуудлуудыг шийдвэрлэдэг. Яаж ингэж чаддаг талаар Шрила Прабхупадагийн номуудад дэлгэрэнгүй тайлбарладаг.

Бурханд зоогийг хайр болон чин бишрэлтэйгээр өргөх.

Бие даасан сүнс бол Кришнаатай хайрын уяа холбоогоор холбогдсон байдаг. Энэхүү хайраа мартчихсан байгаа болохоор л бид одоо материаллаг ертөнцөөр хэрэн тэнэж байгаа хэрэг. Гэхдээ энэ хайраа дахин сэргээж хөгжүүлэх аваас бид Бүхний Дээдтэй холбогдсон холбоогоо сэргээн тогтоож чадна. Хайрлана гэдэг бол ямар нэгэн зүйлээ өгөх, ямар нэгэн зүйлээ зориулах гэсэн үг. Хайр бол идэвхтэй үйлчлэл зүтгэлээр үргэлжид илэрч тодордог. “Би чамд хайртай, гэхдээ чиний төлөө юу ч хийхийг хүсэхгүй байна.” гэх аваас тэнэг сонсогдоно. Энэ бол хайр биш. Материаллаг харьцаанд хүртэл амраг хосууд бие биедээ янз бүрийн бэлэг сэлт өгөх, тансаг нарийн хоол ундаар дайлах болон бие биетэйгээ эрхэм нандин сэдвүүдээр дотно яриа өрнүүлэх зэргээс таашаал ханамж авч эдэлцгээдэг. Хайрын солилцооны тоо томшгүй олон арга замууд байдаг.

Кришна бол мөн л Бодьгал. Бид Түүнд янз бүрийн бэлэг өргөлүүд өргөн Түүнтэй хайраа солилцож болно. Кришна: “Надад навч, цэцэг, жимс эсвэл бага зэргийн ус ч гэсэн хайр болон чин бишрэлтэйгээр өргөх аваас Би энэхүү өргөлийг болгоон таалах болно.” (Б.-г.,9.26) гэсэн маш энгийн аргыг санал болгодог.

Оюунлаг хүн Кришнагийн ухамсарт оршин байхыг үргэлжид эрмэлздэг бөгөөд Бурханы мөнх хийгээд цэнгэл жаргалын биелэл болсон оронд дээшлэн очихоор Түүний трансценденталь хайр дүүрэн чин бишрэлийн албанд зүтгэдэг. Ийм гайхамшигтай үр дүнд хүрэх маш амархан, тэр бүү хэл тусгайлсан мэргэшилгүй, хамгийн ядуу тарчиг хөөрхийлөлтэй хүн ч гэсэн үүнд хөнгөхөн хүрч чадна.

Үүний тулд шаардлагатай байх цорын ганц шалгуур бол Кришнаг бишрэх цэвэр чин бишрэл. Чин бишрэлийн алба зүтгэл бол Бурханд цэцэг эсвэл бага зэргийн усыг хайр дүүрэн өргөснөөр Түүнийг бүрнээ цэнгүүлж болдог тийм энгийн. Иймээс Бурханд хүрэх энэхүү энгийн хийгээд түгээмэл (универсал) аргыг хэн бүр хүлээн авч болно.

Бурханд өргөөгүй хоолыг идэж байгаа хүн бол гагцхүү нүглийг л иддэг.

“Надад юу ч харьяалагддаггүй буюу миний гэсэн юм энд огт байдаггүй. Үр тарианы ургац сайн байхад агаар, гэрэл болон хангалттай хэмжээний ус шаардлагатай. Энэ бүхнийг байгаль хангадаг. Байгаль нь Бурханаас эхлэл гаралтай бөгөөд Түүний хяналт хараан дор байдаг. Тэр бүү хэл миний бие махбодийг хүртэл Бурхан өгсөн бөгөөд би өөрөө бол Кришнагийн жижиг хэсэг. Бүх зүйл Кришнагийнх, Түүнд харьяалагддаг. Иймээс би бүхнийг Түүнд өргөх ёстой.” гэдгийг оюунлаг хүн ойлгодог. Үүнийг хүлээн зөвшөөрөх явдал бол бурханлаг амьдралын эхлэл. Кришна Бхагавад Гита-д ийн айлддаг: “Бурханы чин бишрэлтэнгүүд эхлээд Бурханд өргөсөн хоол хүнсийг хэрэглэдэг тул нүглийн бүхий л хэлбэрээс ангижирдаг. Харин бусад нь буюу зөвхөн өөрсдийн мэдрэхүйн таашаалыг хангах зорилгоор хоол хүнсээ бэлтгэгчид нь үнэн хэрэгтээ зөвхөн нүгэл л идэж байдаг.” (Б.-г., 3.13).

Бурханд өргөөгүй хоолыг идэж байгаа хүн дан ганц нүгэл л иддэг гэж Кришна айлдаж байна. Өөрөөр хэлбэл ийм хүн зажлах бүртээ материаллаг мөн чанарын торонд улам бүр ихээр орооцолддог хэрэг. Амттай цагаан хоол хийж бэлтгээд Радха, Кришна хоёрын хөргийн өмнө нь бишрэл хүндэтгэлтэйгээр мөргөн тэрхүү даруухан өргөлийг нь болгоон таалахыг гуйх аваас Кришна тэрхүү идээ зоогийг заавал болгоон таална. Ийм байдлаар өргөсөн идээ зоогийг хүртсэнээр чин бишрэлтэн бурханлаг амьдралдаа тогтвортой хөгжил дэвшлийг гаргах бөгөөд бие махбодио ариусгадаг. Түүнээс гадна, сэтгэхүйн хурц тод байдлыг хариуцсан тархины нарийн эд эсээ сайжруулдаг. Кришна бүтээл дэх бүхнийхээ Эзэн нь учраас Түүнд хоол хэрэггүй, гэхдээ Түүнийг ийм аргаар цэнгүүлэхийг хүсэж байгаа хүний бэлэг өргөлийг Тэрээр хүлээн авдаг буюу болгоон таалдаг. Хоол бэлтгэж, хийж байхдаа ухаанаа үйлчлэн зүтгэж байгаа тийм төлөв байдалд оруулж автуулах, мөн өргөлөө Кришнад хайр дүүрэн өргөх хэрэгтэй.

Ариун гэгээн нэр алдрыг давтан унших нь орчин үеийн хүмүүсийн хувьд өөрийгөө ухаарч танин мэдэхүйн тохиромжтой арга.

Орчин үеийн хүмүүсийг бурханлаг үйлэнд зүтгэх тал дээрээ тун тааруухан гэж тодорхойлж болно. Өмнөх цаг үе буюу юга-нуудад хүмүүсийн ухамсар илүү дээд түвшинд байсан болохоор бурханлаг зам мөрдөө хөгжил дэвшил гаргах нь тэдний хувьд хавьгүй амар хялбар байсан. Бүр эрт дээр цагт хүмүүс бараг бүгдээрээ цэвэр ариуны гунад байсан бөгөөд нийгэм нь шашин номын зарчмууд дээр үндэслэгдсэн эв эетэй, тайван амгалан амьдралаар амьдарч байсан. Тэр цаг үед зөвлөмж болгосон шашны хэлбэр бол бясалгал байв. Цаг үеүд улиран өнгөрөхийн хирээр хүний нийгэм уналт доройтолд бүрмөсөн орсон. 5000 жилийн өмнө тэртээ, Бурхан Кришна найз Арджунадаа найман шатлалт йогыг хэрэгжүүлэхийг зөвлөхөд тэрээр тэрхүү аргыг хэрэгжүүлэхэд хүнд бэрх, тохиромжтой бус хэмээн үзээд хүлээн аваагүй. Илүү нарийн төвөгтэй үйлүүдийг зөвлөмж болгодог байсан өмнөх цаг үеүдэд ч гэсэн Бүхний Дээд Бурханыг чин бишрэх явдал бол өөрийгөө ухаарч танин мэдэхүйн зорилго үргэлж хэвээр байсаар байсан билээ. Кришнагийн ариун гэгээн нэрийг хамтдаа дуулах нь энэ цаг үе дэх чин бишрэлийн алба зүтгэлийн нэн хялбар хэлбэр. Бурханлаг үйлийн энэхүү хэлбэрийг энэ цаг үеийн Шашин болгон зөвлөсөн болой. Брихан-Нарадия-Пуранад батлан өгүүлсэнчлэн: “Хэрүүл тэмцэл болон бялангачлалын энэхүү цаг үед ангижралд хүрэх цорын ганц арга зам бол Бурханы ариун гэгээн нэрийг давтан хэлэх. Өөр зам байхгүй. Өөр зам байхгүй. Өөр зам байхгүй.”

Онцгойлон Харе Кришна маха-мантра-г (маха гэж “аугаа”, мантра гэж “ухааныг харанхуй мунхагаас ангижруулдаг дуу авианы хэлбэлзэл” гэсэн утгатай) давтан уншихыг зөвлөдөг.

Харе Кришна Харе Кришна Кришна Кришна Харе Харе
Харе Рама Харе Рама Рама Рама Харе Харе

Давтан унших арга бол маш энгийн, мөн түүний зэрэгцээ эрхэм дээд, ямар ч цагт, мөн хаана ч байсан гэсэн давтан уншиж болдог. Хуурмаг алдар хүндийн мэдрэмжээс бүрнээ ангид байж, модноос

ч илүү их тэсвэр тэвчээрийг үзүүлж, хүлцэнгүй байдалтайгаар давтан уншсанаар асар их аз жаргал болон амар амгаланд хүрч болно Ийм түвшинд хүрсэн хүнд ариун гэгээн нэрийг давтан унших үйл хөнгөн болдог. Ямар ч хүн ариун гэгээн нэрийг ийм байдлаар, онцгой төвөггүйгээр давтан уншиж болдог.

Ариун гэгээн нэрийг давтан унших нь хүн ямар бие махбодтой, ямар анги давхаргад хамаарагддаг, хангалттай хэмжээний материаллаг мэргэшил боловсролтой эсвэл буянтай юу гэдгээс үл хамааран хэн бүхэнд өршөөл ивээлээ үзүүлж, хайрладаг. Дээд гарал язгуур, маш өндөр боловсрол мэдлэг, гоо үзэсгэлэнтэй гадаад дүр төрх, баян чинээлэг амьдрал ахуй болон буянтай сайн үйлийн тэдгээртэй адилтгах үр дүнгүүд нь хүний бурханлаг хөгжил дэвшилд ямар ч үүрэг рольгүй. Хөгжил дэвшил зөвхөн Кришнагийн нэрийг давтан уншсаны ачаар болж явагддаг.

Идэвхтэй амьдралын хэлбэрээр амьдарч байгаа хүн ажил үүргээ гүйцэтгэх болон ариун гэгээн нэрийг унших гэсэн хоёр үйлд яаж нэгэн зэрэг зүтгэж чадах юм бэ? гэсэн асуулт олон хүмүүст төрдөг. Хайр байх аваас энэ бол боломжтой. Жишээ нь, хүү нь өвчтэй байгаа эцэг өдөржингөө ажил албан дээрээ байх ч хүүдээ хайртай тэрээр “Хүү минь ямархуу байгаа бол?” гэж байнгад боддог. Эсвэл өөр нэгэн жишээ, эр нөхөртэй буюу гэрлэсэн эмэгтэй өөр хэн нэгэн эрэгтэйд дурлаж хайртай болжээ гэж бодъё. Ийм эмэгтэй гэр орныхоо ажлыг хийнгээ амраг хайртынхаа тухай үргэлж боддог. Тэр бүү хэл, эр нөхөртөө мэдэгдэхгүйн тулд тэрээр гэр орныхоо ажлыг урьд өмнөхөөсөө ч илүү нягт нямбай, сайн хийхийг чармайдаг. Яг л үүн лугаа, бид материаллаг үүргээ биелүүлж байсан ч тэр дээдийн дээд Амраг хайрт Шри Кришнагийнхаа тухай байнгад бодож санаж байх ёстой.

Бурханлаг үйлэнд гаргах, зориулах цаг зав огт байдаггүй, гардаггүй гэж хэн ч хэлж байж болохгүй. Тэр бүү хэл хамгийн их завгүй, ажил алба ихтэй хүн байсан ч тэр сонин, сэтгүүл гүйлгэж харахын тулд өдөр бүр л цаг гаргадаг бөгөөд бараг хүн бүр өдөр болгон телевизор үздэг. Үлэмж их цаг хугацааг хий хоосон яриа өрнүүлэхэд гаргадаг, зарцуулдаг. Эдгээр цаг хугацааны ихээхэн хэсгийг чин бишрэлийн алба зүтгэлийн үйлэнд зориулж болно. Чин бишрэлтэн цаг зав гаргахыг бүхий л хүчээрээ хичээж чармайж байлаа ч нийгмийн болон ажил мэргэжлийнхээ үүргүүддээ хэт ихээр дарагдан байх аваас амьдралынхаа хэлбэрийг өөрчлөх талаар бодож үзэх хэрэгтэй.

Чин бишрэлийн бодит үйлчлэл зүтгэл.

Хүн бүр ямар нэгэн ажил үйл хийж үйлдэх ёстой билээ, гэхдээ өөрийнхөө хэрэгцээг хангахын төлөөнөө ажиллах аваас тэрээр зөвхөн кармын үр дагаврыг л хурааж хуримтлуулах болно. Бурхан Кришна Бхагавад Гита-гийн (3.9)-д: Аливаа үйлээ Вишнуд өргөл болгон үйлдэх ёстой, эс тэгэх аваас тэр үйл чиний энэ ертөнцөд боолчлогдон байхын учир шалтгаан болно гэж айлддаг.

Ажил үйлийнхээ хэлбэрийг сольж өөрчлөх хэрэг байхгүй. Та зохиолч бол Кришнад зориулан бич. Зураач бол Кришнад зориулан бүтээ. Та нарийн бичгийн дарга байх аваас компьютераараа Кришнад зориулан бич. Танд чөлөөтэй цаг гарч байгаа бол сүмд үйлчлэн зүтгэж байгаа чин бишрэлтэнгүүдэд тусалж болно, эсвэл олсон орлогынхоо тодорхой хэсгийг сүмийн үйл ажиллагааг хэвийн явуулах болон Кришнагийн ухамсрыг номлон түгээн дэлгэрүүлэх үйлсэд зориулан өргөж болно. Сүмээс гадуур амьдардаг чин бишрэлтэнгүүд чин бишрэлийн алба зүтгэлийн талаарх номуудыг худалдан авдаг, найз нөхөд болон танил талууддаа түгээдэг. Олон чин бишрэлтэнгүүд бие биенийдээ зочлон очиж хамтдаа Бурханд чин бишрэлээ илэрхийлдэг, Түүнийг магтан дуулдаг, мөн бичээсүүдийг үзэж судалдаг.

www.vyasa.ru-гаас Чандра Бхавана даса орчуулав.